

“АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГА”-ЫН ТАЛААРХИ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Эрх зүйн дүн шинжилгээ)

**ЗАХИАЛАГЧ: ХЗДХЯ, ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН
АГЕНТЛАГИЙН ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ
“ИРГЭДИЙН ОРОЛЦОО II” ТӨСӨЛ**

ГҮЙЦЭТГЭСЭН: “ИРГЭДЭД ТУСЛАХ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨВ” ТББ

**УЛААНБААТАР ХОТ
2018 ОН**

“АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГА”-ЫН ТАЛААРХИ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нийгмийн харилцаанд оролцогч субъектыг ерөнхий байдлаар хувь хүн болон байгууллага гэсэн 2 хэлбэрт хуваан үзэж болох бөгөөд хууль зүйн хувьд ч ялгаатай зохицуулалт үйлчилдэг.

Монгол Улсын Иргэний хуулийн¹ 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна.” хэмээн тодорхойлжээ.

Өөрөөр хэлбэл, нийгмийн харилцаанд зөвхөн нэг иргэн төдийгүй хэд хэдэн иргэн өөрсдийн ашиг сонирхол, хүсэл зоригоо нэгтгэн нэгдмэл эд хөрөнгөтэй байж, эрх зүйн нэг этгээдийн хувьд эрх олж авч, үүрэг бий болгож, эрх, үүрэг хэрэгжүүлж, эрх зүйн тодорхой үр дагаврыг хариуцах шаардлага тулгардаг.

Ийнхүү зохион байгуулагдаж, нэгдэж буй хэлбэрийг нийгмийн утгаар нь “байгууллага” хэмээн нэрийддэг² бөгөөд “байгууллага” нь хуулийн этгээдийн эрхтэй болон хуулийн этгээд эрхгүйгээр эрх зүйн харилцаанд оролцох боломжтой байна.³

Түүнчлэн өнөөдөр манай улсад үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалтын хүрээнд байгууллагыг зорилгоос нь хамаарч ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байгууллага, чиг үүргээс нь хамаарч төрийн болон бусад байгууллага, өмчийн хэлбэрээр нь нийтийн, хувийн, холимог, эрх зүйн байдлаас нь хамаарч үндэсний, олон улсын болон гадаад улсын байгууллага, зохион байгуулалтын хэлбэрээр нь энгийн болон нийлмэл(хуулийн этгээдүүдийн нэгдэл), үйл ажиллагаа явуулах газар нутгийн харьяаллаар нь төв болон орон нутгийн гэж нийтлэг байдлаар ангилахаас гадна үйл ажиллагааны чиглэлээс нь хамаарч боловсролын, эрүүл мэндийн, хүмүүнлэгийн, улс төрийн, хэвлэл мэдээллийн, шашны гэх зэргээр тусгайлан нэрлэн ангилж болохоор байна.

“Байгууллагын эрх зүйн байдал” буюу эрх, үүрэг, хариуцлагыг тэдгээрийн зорилго, чиг үүрэг, зохион байгуулалтын хэлбэр, үйл ажиллагааны чиглэл зэргээс хамаарч хуулиар ялгаатай зохицуулдаг.

Иймд энэхүү судалгаагаар “ашгийн бус” хэмээн нэрлэгддэг байгууллагыг хамруулан, тэдгээрийн ялгаатай болон нийтлэг шинж, онцлог төрлүүдийг Монгол Улсын хуулиар хэрхэн тодорхойлон зохицуулж байгаад үнэлгээ хийхийг зорьсон болно.

¹ www.legalinfo.mn – сүүлчийн нэвтрэлт 2018 оны 2 дугаар сарын 20.

² Н.Чинбат, Иргэний эрх зүй, лекцийн товчоон (ерөнхий анги), Улаанбаатар, 2014 он, 82 дахь тал.

³ “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна.” Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг

НЭГ.АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Хуулиар ашгийн бус хуулийн этгээд, түүний тодорхой хэлбэрүүд⁴ болон нэгдэлийг⁵ тодорхойлсон байдлаас дүгнэхэд хэд хэдэн этгээд тодорхой (нийтийн болон гишүүдийнхээ сайн сайхан, эрх ашгийг хамгаалах)⁶ зорилгын дагуу(хууль болон дүрмээр тодорхойлсон)⁷ нэгдэн нэг этгээдийн хувьд эрх зүйн харилцаанд оролцон, үйл ажиллагаанаас олсон орлогоосоо ашиг хуваарьлахгүйгээр үндсэн зорилгоо хэрэгжүүлэхэд зарцуулдаг⁸ нэгдэлийг “Ашгийн бус байгууллага” хэмээн тодорхойлж болох юм.

Иймд дээрх шинжийг харгалзан тодорхойлбол “Ашгийн бус байгууллага”-д төрийн болон ашгийн бус бусад байгууллага аль аль нь хамаараахаар байна.

Түүнчлэн эдгээр байгууллагууд нь хуулийн этгээдийн эрхтэй болон эрхгүй байж болно.

1. Төрийн болон ашгийн бус бусад байгууллага:

Төрийн байгууллагыг төр өөрийн үндсэн чиг үүрэг буюу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хүрээнд тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх, нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилгоор хуулийн дагуу байгуулдаг.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ.” гээд төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хэмээн ангилсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд зааснаар төрийн байгууллага нь өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах эрхтэй бөгөөд улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах үүрэгтэй байна.

Харин Иргэний хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар буюу хамтран хуулийн этгээд байгуулж болно” гэж заасан байна.

⁴Иргэний хуулийн 37, 38 дугаар зүйл болон ашгийн бус хуулийн этгээдийн тодорхой төрлийн эрх зүйн байдлыг тогтоосон бусад хуулиудын холбогдох зохицуулалт. Тухайлбал, Төрийн бус байгууллагын тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай, Улс төрийн намын тухай, үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль гэх мэт.

⁵ Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг.

⁶ Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг,

⁷ Иргэний хуулийн 37 дугаар зүйл, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1/.

⁸ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

Үүнээс дүгнэхэд төрийн байгууллага нь хэдийгээр ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулдаг боловч засаглалыг хэрэгжүүлэх чиг үүргийн онцлогоос хамаарч бүртгэл, хяналт болон санхүүжилт, түүний зарцуулалт нь бусад ашгийн бус байгууллагаас тусдаа зохицуулагдаг.

Энэ ч утгаараа өнөөдөр Монгол Улсад үйлчилж буй “ашгийн бус байгууллага”-тай холбоотой эрх зүйн зохицуултын хүрээнд төрийн байгууллагаас бусад ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг хамруулсан бөгөөд Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Ашийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хорошшны хэлбэрээр байгуулна.” гэжээ.

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төрийн бус байгууллага гэж иргэд, **төрийн байгууллагаас бусад хуулийн этгээдээс** нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа **төрөөс хараат бус**, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг **ашгийн төлөө бус байгууллага**” гэж заасан.

Тус зохицуулалтаас үзэхэд төрийн байгууллагаас бусад ашиг олох зорилгогүй байгууллагыг Төрийн бус байгууллага /цаашид ТББ гэх/-д хамруулж ойлгохоор байна. Өөрөөр хэлбэл, “ТББ” гэдэгт улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага төдийгүй боловсрол, соёл урлаг, хэвлэл мэдээллийн гээд бүхий л салбарт ашиг олох зорилгогүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагаас бусад байгууллагыг хамааруулахаар байна.

Мөн Төрийн бус байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлд “энэ хууль нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийдээс **бусад төрийн бус байгууллагад** хамаарна” гэж заасан байна.

Иймд нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийд нь төрийн бус байгууллага боловч тэдгээрийн эрх зүйн байдал, холбогдох харилцааг өөр хуулиар зохицуулах тул эдгэрээс бусад төрийн бус, ашгийн бус байгууллагуудтай холбоотой харилцааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулсан хэмээн дүгнэж болох юм.

Гэвч практикт ашгийн бус байгууллагад(хуулийн этгээд болон хуулийн этгээдийн эрхгүй) тавигдах нийтлэг шаардлагыг нэгдсэн байдлаар тодорхой хуульчлаагүй, ашгийн бус хуулийн этгээдийн төрлийг холбоо, сан, хоршоо хэмээн⁹ хязгаарлан зохицуулсны улмаас бүртгэл хяналтын тогтоцлоо суларч, ТББ-ын нэрээр ашиг олох үйл ажиллагаа явуулах, бүртгэл, хяналтын тусгай зохицуулалт шаардлагатай ашгийн бус байгууллагууд ч(шашны болон улс төрийн намыг дэмжих зорилго бүхий байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэх мэт) хуулийн хийдлийг ашиглан хяналтаас гадуур үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэн гэж үзэхээр байна.

⁹ Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг.

2. Хуулийн этгээдийн эрхтэй болон хуулийн этгээдийн эрхгүй ашгийн бус байгууллага:

Иргэний хуульд хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь **хамтран ажиллах гэрээгээр**¹⁰ болон **бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөлийн**¹¹, эсхүл **хуулийн этгээдийн нэгдэл**¹² хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болохоор хуульчилсан байна.

Төрийн бус байгууллагын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлд “Үүсгэн байгуулагчдаас төрийн бус байгууллага байгуулах тухай шийдвэр гаргаж байгууллагын **дүрмийг баталснаар төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулсанд тооцох** бөгөөд **улсын бүртгэлд бүртгүүлснээр хуулийн этгээдийн эрх эдэлнэ.**” гэснээс үзэхэд ТББ нь хуулийн этгээдийн эрхтэй болон эрхгүй хэлбэрээр оршин байх боломжтой мэт байна.

Гэвч Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд “Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ. Хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгүүлэхээсээ өмнө иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохыг хориглоно.” гэж заасан тул ТББ-ын хувьд заавал улсын бүртгэлд бүртгүүлсэн нөхцөлд иргэний эрх зүйн харилцаанд оролцох эрх нь үүсэхээр байна.

Иргэний хуулийн 476 дугаар зүйлд заасны дагуу хамтран ажиллах гэрээгээр “ашиг олох болон бусад тодорхой зорилгоор” хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байгуулан ажиллаж болохоор заажээ. Гэвч хамтран ажиллах гэрээний талууд нь бүрдүүлсэн хөрөнгөө өмчлөх эрхийг хадгалахын¹³ зэрэгцээ орлогоос гишүүдэд ашиг хуваарьлахаар¹⁴ зохицуулсан байна. Харин Иргэний хуулийн 481 дүгээр зүйлд заасны дагуу бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөлийн хэлбэрээр ажиллахад ашиг хуваарьлах талаар тусгайлан зохицуулаагүй ч гишүүдийн татвар, хандив, үйл ажиллагааны орлогоос олж авсан хөрөнгө нь гишүүдийн дундын хөрөнгө байхаар байна.

Эдгээрээс дүгнэхэд хамтран ажиллах болон бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөлийн хэлбэрээр ашгийн бус хуулийн этгээдийн эрхгүй байгуулагыг байгуулах боломжгүй байна.

Манай улсын хувьд бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөлийн хамгийн түгээмэл хэлбэр нь сууц өмчлөгчдийн холбоо/СӨХ гэх/¹⁵ болон байгаль

¹⁰ Иргэний хуулийн 476 дугаар зүйлийн 476.1 дэх хэсэг

¹¹ Иргэний хуулийн 481 дүгээр зүйл.

¹² Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг

¹³ Иргэний хуулийн 477 дугаар зүйлийн 477.3 дахь хэсэг.

¹⁴ Иргэний хуулийн 478 дугаар зүйлийн 478.8 дахь хэсэг.

¹⁵ “сууц өмчлөгчдийн холбоо” гэж нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх эрхийг хэрэгжүүлэх, тухайн орон сууцны байшингийн ашиглалтын хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг

хамгаалах чиглэлээр байгуулагдсан байгаль орчныг хамгаалах¹⁶, ой хамгаалах¹⁷ нөхөрлөл юм.

Иргэний хууль¹⁸ болон Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн тодорхойлолтоос үзэхэд СӨХ нь сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, орон сууц ашиглалтын хэвийн байдлыг хангах зорилготой, сангийн хөрөнгийг зөвхөн зориулалтын дагуу ашиглахаар зааснаас үзэхэд ашгийн бус байгууллага гэж үзэхээр байна, харин байгаль орчныг хамгаалах, ой хамгаалах нөхөрлөл нь үйл ажиллагааныхаа үр шимийг гишүүддээ хуваарьлах¹⁹-аар заасан тул ашгийн төлөөх зорилготой хэмээн тодорхойлж болохоор байна.

Харин Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэгт зааснаар хуулийн этгээдийн нэгдэл нь ашгийн бус зорилгоор нэгдэн хуулийн этгээдийн эрхтэй(нэгдэл нь бие даасан хуулийн этгээдийн эрхтэй байх) болон хуулийн этгээдийн эрхгүй хэлбэрээр ажиллаж болохоор байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллээс үзэхэд ТББ-ууд дээрх 2 хэлбэрийг түгээмэл ашиглаж байна. Тухайлбал, Монфемнет ТББ(Эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гишүүнчлэл бүхий ТББ-уудын нэгдэл боловч, бие даасан хуулийн этгээдийн эрхтэй ТББ)²⁰, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ(2007 онд төрийн бус 10 байгууллага хамтран сүлжээний хэлбэрээр нэгдэж ажиллахаар зохион байгуулагдсан бөгөөд 2008 онд хуулийн этгээдээр бүртгүүлсэн)²¹, “Хүний наймааны эсрэг ТББ-уудын сүлжээ” нь 19 бие даасан хуулийн этгээдийн хамтын ажиллагааны нэгдэл²² бөгөөд бие даасан хуулийн этгээдийн эрхгүйгээр үйл ажиллагаа явуулдаг байна.

хамгаалах, орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг эрхлэн хариуцах зорилго бүхий, хуулийн этгээдийн эрхгүй, заавал гишүүнчлэлтэй холбоог. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт.

¹⁶ “байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл” гэж /цаашид “нөхөрлөл” гэх/ нутгийн иргэдэд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхийг олгож, нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс гарсан үр ашгийг иргэдэд тэнцүү хуваарилах зорилготой нөхөрлөлийг. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8/ дахь заалт.

¹⁷ “ойн нөхөрлөл” гэж Иргэний хуулийн 481.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.8-д заасны дагуу зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн сайн дурын байгууллагыг. Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 духаа заалт.

¹⁸ Иргэний хуулийн 143 дугаар зүйл. www.legalinfo.mn нэвтрэлт 2018 оны 2 дугаар сарын 20

¹⁹ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.8 дахь заалт. www.legalinfo.mn – сүүлчийн нэвтрэлт 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдөр.

²⁰ www.monfemnet.org- цахим хуудсан дахь танилцуулга

²¹ www.irgen-tur.mn - цахим хуудсан дахь танилцуулга

²² Европын холбоо Каритас Чех байгууллагын санхүүжилттэйгээр ХАБСТ-т санаачлан 19-н ТББ-г нэгтгэн 2 жилийн хугацаатай “Хүний наймааны эсрэг ТББ-уудын сүлжээ”-г байгууллаа. Тус сүлжээний зорилго бол Монгол улсад хүний наймааны эсрэг үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын хамтын ажиллагааг бэхжүүлэн, чадавхижуулах юм. Лантуун дохио ТББ-ын мэдээлэл. 2017 он

Хуулийн холбогдох зохицуулалтаас үзэхэд хуулийн этгээдийн нэгдэл хэлбэрээр ажиллахад оролцогч нь заавал хуулийн этгээд байх шаардлагатай.

Гэтэл хувь иргэд ашгийн бус зорилгоор нэгдэн үйл ажиллагаа явуулах нь түгээмэл байдаг ч энэ тохиолдолд Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээгээр болон бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөлийн хэлбэрээр ажиллах боломжтой эсэх нь эргэлзээтэй байна.

Үүнээс хамаарч өнөөгийн практикт иргэд өөрсдийн эрх ашгийг хамгаалах, сонирхлоо хөгжүүлэх зорилгоор нэгдэн ажиллахдаа ТББ-ыг байгуулж байна.

Ийнхүү ашгийн бус хуулийн этгээдээр бүртгүүлсэн нөхцөлд эдгээр хязгаарлагдмал хүрээнд ажилладаг бүлгүүд нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг жил бүр төрийн байгууллагад тайлагнах, үйл ажиллагааг олон нийтэд ил тод байлгах, татан буугдсан нөхцөлд хөрөнгийг зөвхөн адил төрлийн үйл ажиллагаанд зарцуулах, сангийн хэлбэрээр байгуулагдаагүй л бол хувь гишүүдийнхээ үйл ажиллагааг санхүүгийн хувьд дэмжих боломж нь хязгаарлагддаг.

Түүнчлэн зарим төрлийн үйл ажиллагаанд оролцох эрхийг авахын тулд заавал тусгай эрх бүхий субъектийн тодорхой хувийг нэгтгэсэн гишүүнчлэл бүхий хуулийн этгээд байхыг шаарддаг байна.

Тухайлбал, үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаанд нийт тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээдийн тавиас дээш хувийн гишүүнчлэлтэй²³, гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа болон ёс зүйн нийтлэг журмыг тогтоох, гишүүдийнхээ чадавхыг дээшлүүлэх, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах үндсэн зорилго бүхий мэргэжлийн холбоо, хөрөнгийн бирж, үнэт цаасны тооцооны байгууллага болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагыг²⁴ өөрийгөө зохицуулах байгууллагаар бүртгэн тусгай эрх олгодог байна.²⁵

Өөрөөр хэлбэл, өөрийгөө зохицуулах байгууллага нь шинээр хуулийн этгээд үүсгэхгүйгээр үнэт цаасны зах зээлд оролцох тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд, мэргэжилтнийг гишүүчлэлд хамруулж, улмаар хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлснээр “өөрийгөө зохицуулах байгууллага” -ын эрхийг эдлэх боломж бүрддэг байна.

Үүнээс дүгнэхэд үнэт цаасны зах зээлд оролцогч “өөрийгөө зохицуулах байгууллага” нь хуулийн этгээд болон хувь мэргэжилтний гишүүнчлэлтэй байх бөгөөд шинээр хуулийн этгээд үүсгэх бус харин гишүүдийг өөрийн хуулийн этгээдийн нэр дээр гишүүнчлэлд хамруулж(мэргэжлийн холбоо, хөрөнгийн бирж, үнэт цаасны тооцооны байгууллага болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн

²³ Үнэт цаасны зах зээлийн тухай тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалт.

²⁴ Үнэт цаасны зах зээлийн тухай тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсэг.

²⁵ Үнэт цаасны зах зээлийн тухай тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг.

байгууллага) байгаагаас үзэхэд Иргэний хуульд заасан бүртгэгдээгүй холбооны хэлбэр юм.

Гэвч энэхүү бүртгэгдээгүй холбоо нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлснээр үнэт цаасны мэргэжлийн үйл ажиллагаанд оролцох эрх нь үүсэх²⁶ бөгөөд дээрх зорилгоос гадна мэргэжилтэнд олгох үйлчилгээний төрөл, мэргэшлийн зэрэглэлийг тогтоох²⁷, мэргэжлийн зөвлөлийн гишүүнийг томилох талаар санал гаргах²⁸, брокерийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг батлах²⁹, гишүүдийн ёс зүйтэй холбоотой гомдол, маргааныг шийдвэрлэх³⁰, мэргэжлийн сургалт явуулах, давтан сургах³¹, өөрийн дүрэм, журмаар тогтоосон хүрээнд гишүүдийнхээ үйл ажиллагааг шалгах, зөрчлийг арилгуулах талаар үүрэг өгөх, зөрчлийн хэмжээнээс хамаарч гишүүний тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг Санхүүгийн зохицуулах хороонд гаргах³² чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна.

Иймд зөвхөн гишүүддээ үйлчлэх зорилгоор ашгийн бус үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн нэгдэл нь заавал хуулийн этгээдээр бүртгүүлэхгүйгээр Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээ болон бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөлийн хэлбэрээр ажиллаж болохыг тодорхой заах, мөн энэ нөхцөлд зөвхөн үндсэн зорилгоо хэрэгжүүлэх хүрээнд л аж ахуйн үйл ажиллагаа явуулахаар хязгаарлах зэргээр ашгийн төлөөх байгууллагаас ялгаатай зохицуулах нь зүйтэй байна.

3. Үндэсний болон гадаад улсын ашгийн бус байгууллага:

Монгол Улсад хуульд заасны дагуу үндэсний, олон улсын болон гадаад улсын байгууллага нь үйл ажиллагаа явуулах эрхтэй байна.

Үндэсний ашгийн бус хуулийн этгээд нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу³³ Оюуны өмч, улсыг бүртгэлийн газрын/ОӨУБГ/ цаашид хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлснээр эрх зүйн харилцаанд бие даан оролцох эрх нь үүсдэг бол олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу³⁴ Гадаадын иргэн харьяатын газраас /цаашид ГИХГ гэх/зөвшөөрөл авсан нөхцөлд Монгол Улсад үйл ажиллагаа явуулах эрх нь үүсэхээр байна.

Эдгээр зохицуулалтын дагуу олон улсын болон гадаадын ТББ-ын салбар, төлөөлөгчийн газрын бүртгэл, хяналтыг Гадаадын иргэн, харьяатын газар

²⁶ Үнэт цаасны зах зээлийн тухай тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг.

²⁷ Үнэт цаасны зах зээлийн тухай тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг.

²⁸ Үнэт цаасны зах зээлийн тухай тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэг.

²⁹ Үнэт цаасны зах зээлийн тухай тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэг.

³⁰ Үнэт цаасны зах зээлийн тухай тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.3 дахь заалт.

³¹ Үнэт цаасны зах зээлийн тухай тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.2 дахь заалт.

³² Үнэт цаасны зах зээлийн тухай тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.6 дахь заалт.

³³ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл.

³⁴ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5 дахь заалт.

хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү бүртгэлийн сангийн мэдээлэл нь ямар нэгэн хэлбэрээр Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын хяналтанд хамаардаггүй байна.³⁵

Хуулиар олон улсын болон гадаадын төрийн бус байгууллагын салбарт зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох эрхийг Гадаадын иргэн, харьяатын газарт олгосон боловч тус зөвшөөрлийг олгох болон олгохоос татгалзах, олгосон зөвшөөрлөө хүчингүй болгох үндэслэл, журам тодорхойгүй, энэ талаарх тусгай журам баталж мөрдүүлэх талаар эрх шилжүүлсэн зохицуулалт байхгүй байна.

Түүнчлэн Төрийн бус байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Энэ хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт дээр байгуулагдан үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон бусад улсын төрийн бус байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газарт нэгэн адил хамаарна." хэмээн заасан.

Өөрөөр хэлбэл, тухайн ТББ нь үндэсний, эсхүл гадаад улсын байхаас үл хамааран хуульд заасан нийтлэг шаардлагыг хангах, бүртгэл, хяналтанд байх ёстой. Энэ ч утгаараа олон улсын болон гадаадын ТББ-ын салбар, төлөөлөгчийн газар нь тус хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Улсын бүртгэлийн газарт жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор үйл ажиллагааныхаа тайланг гаргах үүрэгтэй.

Гэтэл бүртгэл болон үйл ажиллагааны хяналт нь Гадаадын иргэн, харьяатын газарт хамаарах төдийгүй ОӨУБЕГ-ын хуулийн этгээдийн улсын бүртгэл болон ГИХГ-ын мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох болон хамтран хяналт хэрэгжүүлэх ажиллагаа байдаггүй байна.³⁶

Зөрчлийн тухай хуулийн 11.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Хуульд заасан хугацаанд үйл ажиллагааныхаа тайланг холбогдох эрх бүхий байгууллагад гаргаж өгөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно", мөн хуулийн 3.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт "Гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн бол хуулийн этгээдийн нэгэн адил шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ." гэжээ.

Мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.20-д Зөрчлийн тухай хуулийн 11.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчлийг улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлэх эрхтэй байхаар хуульчилсан байна.

Гэтэл гадаадын ТББ-ын салбар, төлөөлөгчийн газрын бүртгэлийг ГИХГ хэрэгжүүлж байгаа ч Төрийн бус байгууллагын тухай хуульд зааснаар тухайн салбар, төлөөлөгчийн газар нь Улсын бүртгэлийн газарт үйл ажиллагааныхаа

³⁵ Улсын бүртгэлийн газрын мэргэжилтэйиэй хийсэн ярилцлага. 2018 оны 1 сар.

³⁶ Улсын бүртгэлийн газрын мэргэжилтэйиэй хийсэн ярилцлага. 2018 оны 1 сар.

тайланг жил бүр гаргах үүрэгтэй, энэхүү үүргээ хэрэгжүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл хүлээхээр байна.

Ийнхүү хууль хоорондын зөрчлөөс хамаарч гадаадын ТББ-ын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй, бодит хэрэгжилтийг хангах боломжгүй болж байна.

Түүнчлэн үндэсний ТББ-ыг шинээр бүртгэхэд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу 44.000 төгрөг, салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэхэд 20.000 төгрөгний хураамж төлдөг³⁷ бол гадаадын ТББ-ын салбар, төлөөлөгчийн газар нээн ажиллуулах зөвшөөрөл өгч, гэрчилгээ олгоход 900.000-2.250.000 төгрөг³⁸, нэгэнт Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын болон гадаадын ТББ-ын салбар, төлөөлөгчийн газарт зөвшөөрөл олгож, гэрчилгээг сунгахад 360.000-900.000 төгрөгний улсын тэмдэгтийн хураамж төлөхөөр³⁹ хуульд заасан байна.

Өөрөөр хэлбэл, гадаадын ТББ-ын салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэх хураамж нь үндэсний ТББ-аас бараг 20-50 дахин, харин ашгийн төлөөх байгууллагаас (гадаадын компанийн төлөөлөгчийн газрын хувьд 1.100.000 төгрөгний хураамж төлдөг)⁴⁰ 1-2 дахин их байна.

Үүнээс гадна Иргэний хуульд заасны дагуу хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхгүй. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаатай холбоотой хариуцлагыг тухайн хуулийн этгээд хариуцах ёстой.

Харин гадаадын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчил үйлдсэн бол хуулийн этгээдийн нэгэн адил тооцогдон ял, шийтгэл хүлээлгэхээр Зөрчлийн тухай⁴¹ болон Эрүүгийн хууль⁴²д хуульчилсан байна.

Үүнээс дүгнэхэд үндэсний хуулийн этгээд буюу ашгийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн хариуцлагыг тухайн хуулийн этгээд хүлээх бол, гадаадын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар өөрийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн хариуцлагыг бие даан хүлээхээр ялгаатай зохицуулсан байна.

4. Ашийн бус байгууллагын төрөл:

Ашгийн бус хуулийн этгээд нь эрх зүйн харилцаанд бие даан оролцогч субъектын хувьд төдийгүй нийгэм, соёл, боловсрол, эрүүл мэндийн гээд бүхий л

³⁷ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2 дахь заалт.

³⁸ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6.26 дахь заалт.

³⁹ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6.27 дахь заалт

⁴⁰ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.1 дэх заалт

⁴¹ Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг.

⁴² Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг.

салбарт үйл ажиллагаа эрхэлдэгийн хувьд төрийн болон олон нийтийн тодорхой хяналтанд байх шаардлагатай байдаг. Нөгөө талаас ашгийн бус хуулийн этгээд нь олон нийт, иргэдийн үүсгэл санаачлага, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхийг хангаж буй механизмын хувьд төрөөс хараат бусаар ажиллах ёстой.

Иймд Төрийн бус байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд төрийн байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүнднээс дангаараа буюу хамтран төрийн бус байгууллага байгуулах эрхтэй.” хэмээн заасан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль нь 2015 оныг хүртэл Иргэний хуультай нийцүүлэн холбоо, сан, шашны байгууллагыг тусад нь бүртгэж байсан боловч 2015 оноос холбоо, санг бүртгэх хуулийн этгээдийн жагсаалтад байхгүй болгож “төрийн бус байгууллага” гэсэн нэг хэлбэрийг нэмж бий болгосон бол Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар ашгийн бус хуулийн этгээд нь ТББ, шашны байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс гадна хэвлэл мэдээллийн болон соёл, боловсролын сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн байгууллагын төрлөөр бүртгэгдэж болохоор заасан байна.⁴³

Гэвч шашны, хэвлэл мэдээллийн, соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн байгууллага гэх хуулийн этгээдийн хэлбэрүүдийг үүсгэсэн байх бөгөөд эдгээр нь холбоо, эсхүл сангийн аль хэлбэртэй болохыг бүртгэдэггүй байна.

Түүнчлэн холбогдох хуульд зааснаар соёл⁴⁴, боловсролын сургалт⁴⁵, эрдэм шинжилгээ⁴⁶, эрүүл мэндийн байгууллага⁴⁷ нь ашгийн болон ашгийн бус байж болохоор байна.

Мөн эрх зүйн байдлыг нь тусгай хуулиар зохицуулж буй үйлдвэрчний эвлэл, Улаан загалмай, Худалдаа аж үйлдвэрийн танхим, улс төрийн нам, сүм хийд зэрэг ашгийн бус байгууллага байна.

Улс төрийн намыг Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу Улсын дээд шүүх⁴⁸, олон улсын болон гадаад улсын ТББ-ын салбар, төлөөлөгчийн газрыг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Гадаадын иргэн,

⁴³ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл.

⁴⁴ “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хууль тогтоомжийн дагуу ашгийн төлөө болон ашгийн төлөө бус соёлын байгууллага байгуулан ажиллуулж болно.” Соёлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1

⁴⁵ Боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус, эсхүл ашгийн төлөө байж болно. Боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг.

⁴⁶ Төрийн бус өмчийн эрдэм шинжилгээний байгууллагыг холбогдох хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулна. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт.

⁴⁷ Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ. Эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг.

⁴⁸ Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг.

харьяатын газар⁴⁹ бүртгэдэг бол бусад ашгийн бус хуулийн этгээдийг Оюуны өмч, улсын бүртгэлийн газар бүртгэдэг.

Сүм хийд буюу шашны байгууллагыг байгуулахаас(аймаг, нийслэлийн ИТХ-аас зөвшөөрөл авдаг) бусад ашгийн бус хуулийн этгээдийг байгуулахад урьдчилан ямар нэгэн зөвшөөрөл авсан байхыг шаарддаггүй.

Иргэний хуульд зааснаар⁵⁰ ашгийн бус хуулийн этгээд нь хуульд заасан зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх бөгөөд үйл ажиллагааг эрхлэх эрх тусгай зөвшөөрөл авсан өдрөөс үүсдэг.

Өөрөөр хэлбэл, ашгийн бус хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийн⁵¹ үндсэн дээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрхлэх бол хуулийн этгээдийг байгуулан, улсын бүртгэлд бүртгүүлсний дараа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрөл авдаг.

Өнөөдрийн байдлаар ашгийн бус байгууллага нь ихэвчлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан боловсрол сургалтын⁵² болон эрүүл мэнд⁵³, нийгмийн халамжийн үйлчилгээ⁵⁴, радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах⁵⁵ зэрэг үйл ажиллагааг эрхэлж байна.

Түүнчлэн номын сангийн үйлчилгээ⁵⁶ болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээг үзүүлэх үүрэг бүхий ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн арга зүйгээр хангахад дэмжлэг үзүүлэх, хохирогчийг түр хамгаалах байраар хангах болон энэ хуульд заасан бусад үйлчилгээ үзүүлэх бол магадлан итгэмжлэгдсэн байхыг⁵⁷ шаардсан байна.

Ашгийн бус байгууллагын бүртгэл болон зарим төрлийн үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл, шалгуурын үндсэн дээр олгогдсон байхаас гадна үйл ажиллагаа нь хууль болон дүрэмд заасан зорилгод нийцэж байгаа эсэх(ашгийн бус байх, хуулиар тусгайлан хориглосон үүргийн биелэлт), орлогын эх үүсвэр болон зарцуулалт, тэр дундаа аж ахуйн үйл ажиллагааны орлогыг үндсэн үйл

⁴⁹ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5 дахь заалт.

⁵⁰ Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.8 дахь хэсэг.

⁵¹ “аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл” гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1.

⁵² Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэг.

⁵³ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12 дахь хэсэг.

⁵⁴ Хөгжлийн өжрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

⁵⁵ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.16.1 дэх заалт.

⁵⁶ Номын сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг.

⁵⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг.

ажиллагаандаа зарцуулж байгаа эсэх нь хуулийн дагуу төрийн болон олон нийтийн хяналтанд байх ёстой.

Өөрөөр хэлбэл, ашгийн бус байгууллагын онцлог төрөл болох соёл, боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэлийн байгууллага, мөн шашны байгууллага нь ашгийн бус байгууллагын хувьд тавигдах хяналтаас гадна энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэгийн хувьд салбарын хяналтанд байх шаардлагатай.

Гэтэл бодит байдалд дээрх чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд нь ТББ, эсхүл ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг компани, нөхөрлөлийн хэлбэрээр бүртгэгддэг тул статистик бүртгэл зөрүүтэй гарах, ТББ, эсхүл ХХК гэсэн статустай тул тусгай зөвшөөрөлд хамаарахгүй бол үйл ажиллагаа нь салбарын хуулиар зохицуулж буй давхар хяналтанд хамрагдахгүй байх зэрэг бэрхшээлийг үүсгэж байна.

Эдгээрийг байгууллагын төрлөөр дэлгэрүүлэн авч үзвэл:

➤ **Шашны байгууллага:**

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 6 дугаар зүйлд “Сүсэгтэн олны шашин-номын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж, шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагыг /цаашид энэ хуульд “сүм хийд” гэх/ шашны байгууллага гэнэ.” гэж заажээ.

Шашны байгууллага байгуулахад аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчийн хурлаас тусгай зөвшөөрөл авсан байхыг хуулиар шаарддаг.

Оюуны өмч, улсын бүртгэлийн газрын 2016 оны мэдээллээс үзэхэд 439 шашны байгууллага бүртгэгдсэн⁵⁸ боловч бодит байдалд 848 шашны байгуулага⁵⁹ үйл ажиллагаа явуулж байгаа нь шалгалтаар тогтоогдсон байна.

Энэ нь нэг талаас шашны байгууллагыг тодорхойлж буй хуулийн зохицуулалт оновчтой бус уламжлалт буюу буддын шашинд хамаарах сүм, хийд, дацан, төв гэсэн хэлбэрээр хязгаарлан тодорхойлсонтой холбоотой (Христийн шашны байгууллага нь ихэвчлэн чуулган, цуглаан гэсэн нэрээр үй ажиллагаа явуулдаг байна.) төдийгүй шашны байгууллагын үйл ажиллагааны хүрээг шашны зан үйл, хурал ном, боловсролын үйл ажиллагаагаар хязгаарлаж шашин дэлгэрүүлэх, сурталчилах, бусад хүмүүнлэг болон буяны үйл ажиллагааг орхигдуулсны улмаас янз бүрийн зохион байгуулалтын хэлбэрээр шашинтай холбоотой үйл ажиллагаа явуулахад хүргэж байна.

⁵⁸ ХЗДХЯ-нд ирүүлсэн Оюун өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 2/10283 дугаар албан бичиг.

⁵⁹ ХЗДХЯ-наас 2016 онд явуулсан шалгалтын тайлан.

Орчин үеийн шашны байгууллагууд уламжлалт хэлбэрээр бус олон нийтийг хамруулсан нээлттэй хэлбэрээр ажиллах болсноор гол төлөв шашны үзэл номлолыг дэлгэрүүлэх, сурталчилахад сүм хийдийг дэмжих зорилготой байгууллагууд нь⁶⁰ ТББ-ын хэлбэрээр бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байна.

Энэ нөхцөлд дээрх байгууллагууд нь хэдийгээр сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулдаг, удирдлагын хувьд сүм хийдээс хараат бус бөгөөд гишүүнчлэл нь нээлттэй, сайн дурын шинжтэй боловч шашны чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд заасан нөхцөл, шалгуурыг давхар ханган ажиллах шаардлагатай.

Ийнхүү хуулийн сул талыг ашиглан шашинтай холбоотой гэдгээ нуун далдалж, өөр арга замаар буюу иргэдийг нийгмийн янз бүрийн хөтөлбөрт хамруулах (боловсрол, эрүүл мэнд, халамжийн гэх мэт) зэргээр тэдэнтэй холбоо тогтоож аажим аажмаар шашны байгууллага, сүм хийдэд элсүүлэх, улмаар гишүүдээрээ дамжуулж нийгмийн аль нэг салбарт нөлөөгөө тогтоох гэсэн зорилго бүхий шашны байгууллагууд ч байна.

Эдгээр байгууллага нь сүсэгтний тоо хэмжээг нэмэгдүүлэх, хүрээгээ тэлэхэд голлон анхаарч, эрх мэдэл, нөлөөллийн төлөө ажилладаг тул аль болох төрийн хяналтаас гадуур ажиллахыг зорьж, үндсэн зорилгоо нуун олон нийтийн байгууллага байгуулах зэргээр халхавчлан ажилладаг байна.

Иймд Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн шинэчлэлд шашны байгууллагыг тусгайлан бүртгэх зохицуулалтыг хэвээр хадгалах шаардлагатай байна.

Түүнчлэн Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн шинэчлэлд шашны байгууллагад тавих шалгуур, хяналтыг илүү зохистой хэлбэрээр тодорхойлох нь зүйтэй байна.

Тухайлбал, шашны байгууллагыг сүм хийд, дацан, төв гэсэн буддын шашны уламжлалт хэлбэрээр байгуулахаар, мөн тэдгээрийн эрхлэх үйл ажиллагааг зөвхөн зан үйл, хурал ном, боловсролын үйл ажиллагаа гэж хязгаарлан тодорхойлсныг өөрчлөх, шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагыг “Шашны байгууллага” гэдэгт багтаан Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулах, улмаар хуулийн этгээдийн өөр хэлбэрээр халхавчлан шашны үйл ажиллагаа эрхлэхийг хориглох, мөн шашны байгууллагыг үүсгэн байгуулах нөхцөл, үүсгэн байгуулагчид тавих шаардлага, шинээр байгуулах болон зөвшөөрлийг сунгах болон гадаадын шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэхэд харгалзах шалгуур, шийдвэрлэх хугацаа, журам болон зөвшөөрлийн хугацаа, түүнчлэн шашны байгууллагын зөвшөөрлийг цуцлах үндэслэлийг тодорхой хуульчлах зэрэг болно.

⁶⁰ Шашин, сүм хийдийн тухайд төрөөс баримилах бодлого, зохицуулалтын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам. Бодлогын судалгааны тайлан. Үндэсний хөгжлийн хүрээлэн. 2015 он.

➤ Хэвлэл мэдээллийн байгууллага:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар хэвлэл мэдээллийн байгууллагыг тусгайлан бүртгэхээр⁶¹ заасан боловч, хэвлэл мэдээллийн байгууллагад ямар байгууллагыг хамруулах талаар хуулийн тодорхой зохицуулалт байхгүй, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон Харилцаа холбооны тухай хуулийн дагуу баталсан журмаар зохицуулж байна.

Хэвлэл мэдээллийн байгууллага нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд сонин сэтгүүл эрхлэн гаргах, цахим мэдээллийн хэрэгслийн хувьд тусгай зөвшөөрөл шаардахгүй⁶², харин өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээг Харилцаа холбооны зохицуулах хорооноос(цаашид ХХЗХ гэх) олгосон зөвшөөрлийн үндсэн дээр⁶³ хэрэгжүүлдэг байна.

Хэвлэл мэдээллийн байгууллага нь ашгийн болон ашгийн бус хуулийн этгээдийн хэлбэрээр улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, Өдрийн сонин, Улаанбаатар телевиз нь ХХК-ны хэлбэрээр, Монголын мэдээ сонин, Үндэсний шуудан нь ТББ-ын статусаар үйл ажиллагаа явуулдаг байна.

2018 оны 1 дүгээр сарын байдлаар хуулийн этгээдийн улсын бүртгэлд 1058 хэвлэл мэдээллийн байгууллага бүртгэгдсэн байна.⁶⁴ Гэтэл 2016 онд Хэвлэлийн хүрээлэнгээс хийсэн судалгаанаас⁶⁵ үзэхэд 485 мэдээллийн хэрэгсэл ажиллаж идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаагаас 101 сонин, 69 радио, 131 ТВ, 98 цахим мэдээллийн хэрэгсэл байна.

Ийнхүү бүртгэл, статистикийн зөрүүтэй байдал нь хэвлэл мэдээллийн байгууллагад ямар байгууллагыг хамруулах талаар нарийвчилсан зохицуулалтгүйн дээр боловсрол, шинжлэх ухааны болон намын дэргэдэх хэвлэл мэдээллийн нэгжийг заавал тусад нь бие даасан хуулийн этгээдийн эрхтэй бүртгэх эсэх нь тодорхойгүйтэй холбоотой байна.

Тухайлбал, Боловсролын тухай хуульд “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага өөрийн харьяа хэвлэл, мэдээллийн ... нэгжтэй байж болно.”, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд “ эрдэм шинжилгээний байгууллага нь ... эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах эрхтэй.”, Улс төрийн намын тухай хуульд “намын хөрөнгөнд дараахь зүйл хамаарна: ...намын хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны орлого” гэж заасан байна.

⁶¹ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл.

⁶² Хэвлэл мэдээллийн эрх зүйн рчин судалгаа. 2016 он. Хэвлэлийн хүрээлэн

⁶³ Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт

⁶⁴ Оюуны өмч, улсын бүртгэлийн газрын статистик мэдээлэл. 2018 оны 1 дүгээр сар.

⁶⁵ www.pressinst.org.mn- цахис хуудасны мэдээлэл.

Гэвч хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд хуулийн этгээд болохоос гадна зарим нэг шалгуур, хяналтын тусгай зохицуулалт шаардлагатай боловч редакцийн хараат бус байдлыг хянах, эзэмшлийн хувь хэмжээг хязгаарлах, төвлөрлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

Өөрөөр хэлбэл, хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл нь бусад аж ахуйн нэгжийн адил Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу бүртгүүлэх ёстой боловч эзэд, компанийн хувь хэмжээг мэдүүлэх үүрэггүй. Ялангуяа сонин хэвлэлийн компанийн эзэмшлийн мэдээллийг ил тод болгох нарийвчилсан хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Хэдийгээр Олон нийтийн радио телевизийн тухай хуулиар редакцийн хараат бус байдлын талаар холбогдох зохицуулалт байгаа боловч энэ нь зөвхөн Олон нийтийн радио телевизэд хамааралтай тул бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үйлчлэхгүй болно.

Цахим мэдээллийн хэрэгслийн хувьд мөн ХХЗХ-нд бүртгүүлэх ёстой боловч зөвхөн “Холбоо барих мэдээлэл, хэрэглэгчийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах төлөөлөгчийн газрын хаяг болон утасны дугаар зэрэг мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах”-ыг шаарддаг.

ХХЗХ-ноос баталсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн “үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өргөн нэвтрүүлгийн хараат бус байдлыг хангах, нээлттэй, ёс зүйтэй байдлыг эрхэмлэх зорилгоор тусгай зөвшөөрлийн эзэмшлийг олон нийтэд ил тод байлгана” гэсний дагуу өргөн нэвтрүүлгийн байгууллагын эзэмшигчийн нэр, хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувь хэмжээг(гадаад улсын хөрөнгө оруулалттай бол аль улсынх болохыг), мөн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, дэлгэрэнгүй хаяг, харилцах утас, хуулийн этгээдийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, удирдах ажилтнуудын нэр, иргэншил зэргийг Зохицуулах хороонд албан бичгээр мэдэгддэг байна.

Үүнээс хамаарч хэвлэл мэдээллийн эзэд, тэдний найз нөхөд, түншлэгчид болон зар сурталчилгааны орлогын эх үүсвэр болж буй этгээдүүд редакцийн агуулга, мэргэжлийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөх нь түгээмэл байна.

Түүнчлэн хэвлэл мэдээллийн салбарт төвлөрлөөс урьдчилан сэргийлэх тусгай зохицуулалт байхгүй, харин Өрсөлдөөний тухай хууль болон ХХЗХ-ны журамд зах зээл дэх давамгайл байдлыг тогтоох, хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах замаар өрсөлдөөнд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх нийтлэг зохицуулалтын хүрээнд өргөн нэвтрүүлгийн болон цахим мэдээллийн хэрэгсэлд хамаарч байна. Хэвлэлийн хүрээлэнгийн мэдээллээр 2016 оны байдлаар 8 компани хэвлэл мэдээллийн хоёр ба түүнээс дээш хэрэгсэл эзэмшиж байна.

Үүнээс Монгол Масс Медиа Групп 6 мэдээллийн хэрэгсэл буюу 5 ТВ, 1 цахим сайтыг, Масс Агентлаг 6 мэдээллийн хэрэгсэл буюу 2 ТВ, 2, сэтгүүл, 1 радио, 1 цахим сайтыг, Монгол Ньюс Групп 5 мэдээллийн хэрэгсэл буюу 3 сонин, 1 ТВ, 1 сайтыг, Медиа Групп 5 мэдээллийн хэрэгсэл буюу 2 сэтгүүл, 1 ТВ, 1 радио, 1 сайтыг, Сэрүүлэг констракшн 4 мэдээллийн хэрэгсэл буюу 2 сонин, 1 ТВ, 1 радиог тус тус эзэмшиж байна.⁶⁶

2016 оны нэгдүгээр сар хүртэлх хугацаанд сонины борлуулалтыг НӨАТ-аас чөлөөлж байсан бол Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийг шинэчлэн баталснаар дээрх хөнгөлөлт, чөлөөлөлт үгүй болжээ. Одоогийн байдлаар хэвлэл мэдээллийн байгууллагын орлого жилийн 50 сая төгрөгнөөс давахад 10 хувийн НӨАТ төлж байна.

Үүнээс дүгнэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын онцлогийг харгалзсан бүртгэл, хяналтын тусгай зохицуулалт шаардлагатай байна.

➤ **Соёл, боловсролын болон эрдэм шинжилгээний байгуулага:**

Тусгайлан улсын бүртгэлд бүртгэхээр заасан соёлын байгууллагын эрх зүйн байдлыг Соёлын тухай хууль, боловсролын сургалтын байгууллагын эрх зүйн байдлыг Боловсролын тухай хууль, эрдэм шинжилгээний байгууллагын эрх зүйн байдлыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Тус байгууллагуудыг ашгийн болон ашгийн бус зорилготой байгуулж болохоор хуульчилсан бөгөөд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулахад урьдчилан зөвшөөрөл авахыг шаарддаг бол боловсролын байгууллагаас явуулах дараахь сургалтын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхлэхээр заажээ:

- их сургууль, дээд сургууль, коллежийн үйл ажиллагаа эрхлэх;
- магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх;
- дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах;
- мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх;
- мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ мэргэжлээр сургалт явуулах.

2018 оны 1 дүгээр сарын байдлаар улсын бүртгэлд 597 боловсролын сургалтын байгууллага бүртгэгдсэн байна⁶⁷. Харин Үндэсний статистикийн мэдээллээр 2013 оны байдлаар бүх шатны боловсролын байгууллага улсын хэмжээнд 2009 байна.⁶⁸

⁶⁶ Хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал. Судалгаа 2016 он. Хэвлэлийн хүрээлэн.

⁶⁷ Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэл. 2018 оны 1 дүгээр сар.

⁶⁸ Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. www.1212.mn

Соёлын тухай хуульд соёлын байгууллага нь заавал хуулийн этгээдийн эрхтэй буюу хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн нөхцөлд үйл ажиллагаа явуулахаар хуульчилсан байна.⁶⁹

Төрийн өмчийнхөөс бусад соёлын байгууллага нь дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, хөнгөлөлттэй зээл, соёлын байгууллагын өөрийн орлого зэрэг санхүүгийн эх үүсвэртэй⁷⁰ байж болох бөгөөд тодорхой төслийг үндэслэн төрөөс санхүүгийн дэмжлэг туслалцаа авч болохоор хуульчилсан байна.⁷¹

Харин соёлын байгууллагын нэг хэлбэр болох “номын сан”-гийн эрх зүйн байдлыг бие даасан хуулиар буюу Номын сангийн тухай хуулиар зохицуулсан байна.

Номын санг улсын, орон нутгийн төсвөөс гадна хувийн хөрөнгөөр хувь хүн, хуулийн этгээд байгуулж болох бөгөөд гахцхүү номын сангийн орчны стандартыг хангасан байхыг шаарддаг байна.⁷² Энэ тохиолдолд номын сангийн санхүүжилт нь гадаад, дотоодын байгууллага, иргэний хандив, тусламж, өөрийн үйл ажиллагааны орлого зэргээс бүрдэхээр, мөн үйл ажиллагааны орлоготой холбоотой хэвлэх цех, дэлгүүр ажиллуулж болохоор хуульчилжээ.⁷³

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг хуулийн этгээдийг “Эрдэм шинжилгээний байгууллага” гэж тодорхойлж⁷⁴, улмаар дараахь хэлбэрээр байгуулж болохоор хуульчилжээ:

- хүрээлэн, төв, лаборатори, зохион бүтээх товчоо, туршилт-үйлдвэрлэл-үйлчилгээний бааз;
- эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага;
- шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл;
- улсын болон орон нутгийн музей, үндэсний номын сан.

Төрийн бус өмчийн эрдэм шинжилгээний байгууллагыг ашгийн болон ашгийн бус хэлбэрээр байгуулж болох бөгөөд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд эрдэм шинжилгээний байгууллагын төрлөөр тусгайлан бүртгэхээр заасан боловч өнөөдрийн байдлаар тус хэлбэрээр бүртгэгдсэн хуулийн этгээд 2 байгаа⁷⁵

⁶⁹ Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг.

⁷⁰ Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг.

⁷¹ Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг.

⁷² “Номын сангийн үйл ажиллагааг номын сангийн орчны стандартыг хангасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, төрийн бус байгууллага, иргэн эрхэлж болно.” Номын сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг.

⁷³ Номын сангийн тухай хуулийн 23 дугаар зүйл.

⁷⁴ Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг.

⁷⁵ Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэл. 2018 оны 1 дүгээр сар.

бол Үндэсний статистикийн мэдээллээр 2016 оны байдлаар эрдэм шинжилгээний байгууллага 61 бүртгэгдсэн байна.⁷⁶

Эрдэм шинжилгээний байгууллага нь компани болон ТББ-н хэлбэрээр бүргүүлэн үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, Эм судлалын хүрээлэн (Монос фарм ХХК), Нүүдлийн соёл иргэншлийн судлах олон улсын хүрээлэн ТББ гэх мэт.

Түүнчлэн их, дээд сургуулиудын харьяанд ч эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг нэгжүүд ажиллаж байна.

Иймд соёл, боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагыг хуулийн этгээдийн тусгай төрөл болгон бүртгэхээс(Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд тусгайлан бүртгэхээр заасан) илүүтэй ашгийн болон ашгийн бус хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд хуульд заасан нийтлэг шаардлагыг хангахад анхаарах шаардлагатай байна.

Үүнээс гадна үйл ажиллагаа явуулах салбарын онцлогоос хамаарсан зохицуулалтыг салбарын хуульд нарийвчлан тусгах, ашгийн бус үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд тавигдах хязгаарлалт болон дэмжлэгийг хуульчлах нь илүү чухал хэмээн дүгнэж байна.

➤ **Эрүүл мэндийн байгууллага:**

Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар “эрүүл мэндийн байгууллага” гэж хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг гэж тодорхойлсон байна.⁷⁷

Эрүүл мэндийн байгууллага нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр байгуулагдсанд тооцогдох бөгөөд дараахь үйл ажиллагаа эрхлэхийн тулд тусгай зөвшөөрөл авна:

- эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх;
- эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх;
- мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, эмийн бодис, угтвар бодис болон эм үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх;
- биологийн идэвхит бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх;
- эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм худалдах; эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх;
- ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх;

⁷⁶ Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. www.1212.mn

⁷⁷ Эрүүл мэндийн тухай хууль

- ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис худалдах болон үйлчилгээ эрхлэх.

Ийнхүү эрүүл мэндийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг авахын тулд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараахь нэмэлт шалгуурыг хангасан байхыг шаарддаг байна.⁷⁸

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлага		
Аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрлийн хууль	тусгай тухай	Үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын саналыг авсан байх
Эрүүл мэндийн хууль	тусгай	Энэ чиглэлд үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагч шийдвэрлэсэн байх
		Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас олгосон хэрэгцээний тодорхойлолт
		Мэргэжлийн үйл ажиллагааны төсөл(тухайн байгууллагын болон тусламж, үйлчилгээний төрөл, төлөвлөсөн байршил, барилга байгууламжийн талбайн төлөвлөлт, хүний нөөцийн бүрэлдэхүүн, техник, технологийн хүчин чадал, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тусгасан байна)
		Эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын барилга нь мэргэжлийн үйл ажиллагааны төсөл болон батлагдсан зураг төсвийн дагуу баригдсан, зориулалтын дагуу ашиглаж болох эсэх талаар холбогдох байгууллагаас шийдвэр гарсан байх
		Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан тухай холбогдох байгууллагын дүгнэлтийн авсан байх
		Эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүний жагсаалт, мэргэжилтний бүртгэлийн дугаар, хөдөлмөрийн харилцаа үүсгэхийг зөвшөөрсөн зөвшөөрөл.

Эрүүл мэндийн байгууллагыг нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааны чиглэлээр төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн хэлбэрээр байгуулж⁷⁹ болохоор хуульд заасан байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн мэдээллээр эрүүл мэндийн байгууллагын хэлбэрээр тусгайлан бүртгэгдсэн хуулийн этгээдийн тоо

⁷⁸ Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсэг.

⁷⁹ Эрүүл мэндийн тухай хуулийн 114дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг.

тодоохойгүй⁸⁰ бөгөөд эдгээр байгууллагууд нь төрийн байгууллага болон компани, ТББ-ын хэлбэрээр бүртгүүлсэн байна.

Үндэсний статистикийн мэдээллээр улсын хэмжээнд 2016 оны байдлаар 1894 эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага байгаагийн 69% нь буюу 1310 нь хувийн эрүүл мэндийн байгууллага байна.⁸¹

Ашгийн бус байгууллагын төрлүүдийг зохицуулсан бусад хуулийн зохицуулалттай харьцуулахад эрүүл мэндийн байгууллагад тавигдах шаардлага нь харьцангуй тодорхой боловч ашгийн бус байгууллагын хувьд тавигдах нийтлэг болон онцгойлон анхаарах тусгай зохицуулалт шаардлагатай байгаа нь харагдаж байна.

➤ **Улс төрийн нам болон түүнийг дэмжигч байгууллага:**

Улс төрийн нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл бөгөөд өнөөдрийн байдлаар Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 27 нам байна.⁸²

Ийнхүү улс төрийн намын бүртгэл, хяналтыг бие даасан хуулиар зохицуулдаг ч улс төрийн намын үйл ажиллагааг дэмждэг, хандив тусламж өгөх зорилготой байгууллагууд нь ТББ-ын хэлбэрээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Тухайлбал, Монголын ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо нь хуулийн этгээдийн бүртгэлээр ТББ юм. Гэтэл тус байгууллага цахим хуудсандаа МАН, МСДН, МҮДН, МН намуудын дэргэд эмэгтэйчүүдийн үүсгэл санаачлагаар эмэгтэйчүүдийн холбоод байгуулагдсан бөгөөд 2000 онд намууд нэгдсэнээр ардчилсан намыг байгуулахад намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагууд нэгдэж монголын ардчилсан эмэгтэйчүүдийн холбоог байгуулсан гээд Монголын ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо нь 21 аймаг 9 дүүрэгт салбар зөвлөлтэй, 98000 гаруй гишүүнтэй, намын бүх шатны шийдвэр гаргах түвшинд төлөөлөлтэй, улс төрийн хүчирхэг эмэгтэйчүүдийн байгууллага болж чадсан хэмээн тодорхойлсон байна.⁸³

Үүнээс үзэхэд улс төрийн намыг дэмжигч байгууллагууд нь тэдний үзэл санааг дэмжих залуу үеийг бэлтгэх, намын үйл ажиллагаа, мөрийн хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан таниулах, намын гишүүдийн хүрээг тэлэх, намд хандив тусламж төвлөрүүлэх зэрэг үйл ажиллагааг эрхэлж байгаагийн хувьд намын дэргэдэх байгууллага юм.

⁸⁰ Тусгайлан бүртгэл гаргах боломжгүй талаар Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас мэдээлэл ирүүлсэн болно.

⁸¹ Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. www.1212.mn

⁸² Улсын дээд шүүхийн бүртгэлийн мэдээлэл. www.supremecourt.mn

⁸³ ТББ-уудын цахим мэдээллийн хуудас.

Өөрөөр хэлбэл, эдгээр байгууллагыг улс төрөөс ангид үйл ажиллагаа явуулдаг ТББ-аар бүртгэх, үйл ажиллагааны хяналтыг Улс төрийн намын тухай хуулийн гадна үлдээх нь оновчтой биш тул эдгээр байгууллагатай холбоотой зохицуулалтыг тус хуульд тусгах нь зүйтэй байна.

➤ **Нийтийн эрх зүйн хуулийн этгээд:**

Улсын бүртгэлийн тухай хуульд нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэсэн ангилалаар тодорхой хуулийн этгээдийг бүртгэхээр заажээ.

Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт “Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар хуульд заасан журмаар байгуулагдсанаар үүсч, татан буугдсанаар дуусгавар болох бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд бусад оролцогчийн адил тэгш эрхтэй оролцоно.” гэжээ.

Гэвч нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг тодорхойлсон хуулийн тодорхойлолт байхгүй байна.

Монгол Улсын Иргэний хуулийн шинжлэх ухааны тайлбарт⁸⁴ “Нийтийн эрх зүйн олонхи хуулийн этгээд нь төр, засаглалын бүрэн эрхтэй байдаг. Тэдгээрт улсын сан хөмрөгийн хувьд эд хөрөнгийн харилцаанд оролцож байгаа төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хамаарна. Нийтийн эрх зүйн хэм хэмжээн дээр үндэслэн байгуулагдсан, төр засаглалын бүрэн эрх хэрэгжүүлдэггүй шинжлэх ухаан, соёл гэгээрлийн, шашны болон төр засаг, нийгэмд тустай чиг үүрэг бүхий бусад байгууллага, албан газар нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна. Эдгээрийн тоонд академи, их сургууль, дунд сургууль, музей, эмнэлэг, халамжийн газар, худалдааны танхим, номын сан, шашны байгууллага зэрэг багтгана. ...Ихэнх тохиолдолд нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь эрх зүйн тусгай чадамжтай байна. өөрөөр хэлбэл, эрх зүйн тусгай актаар тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.” гэжээ.

Үүнээс дүгнэхэд хуулийн этгээд улсын бүртгэлд тусгайлан бүртгэхээр заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь хуулиар олгосон тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас бусад(хуулийн этгээдийн улсын төрийн байгууллага, албан газрыг тусгайлан бүртгэхээр заасан) хуулийн этгээд байхаар байна.

Түүнчлэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг ашгийн төлөөх нөхөрлөл, хоршоо, компани болон ашгийн бус байгууллагын төрөл болох ТББ, шашны, хэвлэл мэдээллийн, соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн байгууллагаас тусад нь бүртгэхээр заасан байна.

Өнөөгийн байдлаар Монголын хуульчдын холбоог нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр бүртгүүлсэн бөгөөд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд

⁸⁴ Монгол Улсын Иргэний хуулийн шинжлэх ухааны тайлбар 49 дэх тал.

“Хуульчдын холбоо”-г хуульчдын заавал гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хэмээн тодорхойлсон.

Хуульчдын холбоо нь хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаас гадна хуульчийн шалгалт зохион байгуулах, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хуульчийн үргэлжилсэн болон албан бус сургалтыг зохион байгуулах, багц цагийг тооцох, Хуульчийн мэргэжлийн дүрэм батлах, сахиулах, Мэргэжлийн хариуцлагын хороо байгуулан ажиллуулах, шүүгчийн сонгон шалгаруулалт зохион байгуулахад оролцох, хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх зэрэг тусгай эрх хэмжээг хуулиар хүлээсэн байна.

Ийнхүү нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна сайн дурын бус албан ёсны гишүүнчлэлтэй байх, хамаарал бүхий этгээдээс заавал дагаж мөрдөх шаардлагатай, зөрчсөн тохиолдолд хууль зүйн тодорхой үр дагавар бүхий хэм хэмжээг тогтоох эрхтэй байдаг байна.

Энэ шинжээр Нотариатчдын танхим, Албан журмын даатгачдын холбоо зэрэг байгууллагууд нийтийн эрх зүйн хуулийн этгээд юм.

Гэтэл эдгээр байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулсан ТББ, мэргэжлийн холбоодтой адилтган ТББ-аар бүртгэх нь үйл ажиллагаанд нь үзүүлэх мэргэжлийн болон зохион байгуулалтын дэмжлэг болон хяналтыг хэрэгжүүлэхэд бэрхшээл үүсгэж байна.

Тухайлбал, Төрийн бус байгууллагын тухай хуульд “төрийн бус байгууллагад албадан оруулахыг хориглоно.”⁸⁵ гэсэн бол Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд “Хуульч бүр Хуульчдын холбооны гишүүн байна”⁸⁶, Даатгалын тухай хуульд “Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Албан журмын даатгачдын холбоо /цаашид “Холбоо” гэх/-нд гишүүн болох үүрэгтэй”⁸⁷ гэж заасан байна.

Төрийн бус байгууллага үйл ажиллагааныхаа тайланг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж өгөх үүргтэй⁸⁸ бол Монголын хуульчдын холбооны үйл ажиллагаанд ХЗДХЯ хяналт тавихаар ⁸⁹, Албан журмын даатгачдын холбоо нь Санхүүгийн зохицуулах хороонд үйл ажиллагаагаа тайлагнах үүрэгтэй⁹⁰ байна.

Түүнчлэн гишүүнчлэл нь сайн дурын үндсэн дээр боловч хуулиар тусгай чиг үүргийг хүлээлгэсэн Үйлдвэрчний эвлэл, Монголын худалдаа аж үйлдвэрийн

⁸⁵ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

⁸⁶ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэг.

⁸⁷ Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйлийн 12¹.1 дэх хэсэг.

⁸⁸ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

⁸⁹ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг.

⁹⁰ Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйлийн 12¹.8 дахь хэсэг.

танхим, Монголын улаан загалмай нийгэмлэг, Үндэсний спортын холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо зэрэг байгууллагууд байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2018 оны 1 дүгээр сарын мэдээллээр 1251 үйлдвэрчний эвлэлийн байгууллага бүртгэгдсэн байна.⁹¹

Үйлдвэрчний эвлэлийн чиг үүрэг, зохион байгуулалтын асуудлыг Төрийн бус байгууллагын тухай хуулиар бус 1991 онд батлагдсан Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд өнгөрсөн 26 жилийн хугацаанд тус хуульд нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчлэлтэй холбоотой 2003, 2015 онуудад тус тус өөрчлөлт оруулсан бол 2015 онд Эрүүгийн болон Зөрчлийн хууль батлагдсантай холбогдуулан хариуцлагын хэсэгт өөрчлөлт оруулсан байна.

Өөрөөр хэлбэл, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль нь 1992 оны Үндсэн хууль, 1997 оны Төрийн бус байгууллагын тухай хууль, 2002 оны Иргэний хуулиас өмнө батлагдсан тул нэр томъёоны хувьд төдийгүй зарчмын хувьд зөрчилдөөнтэй олон асуудал байна.

Нэр томъёоны хувьд хуучин нэршлээр БНМАУ, "захиргаа" гэдэгт БНМАУ-ын төрийн гүйцэтгэн захирамжлах дээд, төв болон орон нутгийн байгууллагыг хамааруулан ойлгоно гэх мэтээр тодорхойлсон байна.

Харин зарчмын хувьд дараахь асуудлууд хөндөгжөж байна. Тухайлбал, тус хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “үйлдвэрчний эвлэлүүд нь сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж холбоо байгуулах...” эрхтэй гэж заасан боловч энэхүү холбоо нь заавал хуулийн этгээдийн эрхтэй байхаар мөн зүйлийн 4 дэх хэсэгт заасан байна.

Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт орон нутгийн болон улсын хэмжээний үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо байх бөгөөд улсын хэмжээний холбоо нь бусад эвлэлүүдээ төлөөлөн Засгийн газар болон ажил олгогч эздийн улсын хэмжээний байгууллагатай хэлэлцээр байгуулах эрхтэй байхаар заасан байна.

Гэвч орон нутгийн болон улсын хэмжээний нэгдсэн холбоонд тавигдах шаардлага(ямар шалгуураар улсын хэмжээний, эсхүл орон нутгийн нэгдсэн холбоо гэж тооцох), гишүүнчлэлийн хувь хэмжээ болон ямар асуудлыг энэ холбоодоор дамжуулан шийдвэрлэх талаар тодорхой зохицуулалт байхгүй байна.

Түүнчлэн тус хуулийн 4³ дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага...үйлвэрчний эвлэлийг ... улсын бүртгэлд бүртгэнэ.” гэж зааснаас үзэхэд “Үйлдвэрчний эвлэл”-ийг хуулийн этгээдийн бие даасан хэлбэрээр бүртгэхээр мэт боловч 2015 онд

⁹¹ Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас мэдээлэл.

батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд бие даасан хэлбэрээр бүртгэлд хамруулах талаар зохицуулалт байхгүй байна. Өөрөөр хэлбэл Үйлдвэрчний эвлэл нь төрийн бус байгууллагаар бүртгүүлэхээр байна.

Мөн хуулийн 4⁵ дугаар зүйлд “Үйлдвэрчний эвлэл Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон өөрийн дүрмийг зөрчсөн нь шүүхээр тогтоогдож, энэ нь түүний үйл ажиллагааг зогсоох үндэслэл болохоор байвал улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага түүнийг улсын бүртгэлээс хасна.” гэж зааснаас үзэхэд “Үйлдвэрчний эвлэл”-ийг албадан татан буулгах буюу үйл ажиллагааг албадан зогсоох шийдвэрийг хэн гаргах нь тодорхойгүй байна.

Үүгээр ч зогсохгүй шүүхээс тухайн үйлдвэрчний эвлэл нь ямар нэгэн байдлаар энэ хуулийг болон өөрийнхөө дүрмийг зөрчсөн гэж тогтоосон бол түүнийг хуулийн этгээдийг татан буулгах үндэслэл болгох эсэх болон татан буулгах эсэхийг улсын бүртгэлийн газар тогтоох, улмаар хуулийн этгээдийн эрхийг нь цуцалж, улсын бүртгэлээс хасах шийдвэрийг гаргах мэт явцуу зохицуулалт болсон байна.

Хуулийн 7 дугаар зүйлд “үйлдвэрчний эвлэл нь өөрөө санхүүжих зарчмаар ажиллана... хөрөнгө нь гишүүдийн татвар, хандив, үйл ажиллагаа явуулахад шаардагдах бусад эд юмсаас бүрдэнэ.” гэж зохицуулсан бөгөөд үүнээс хандив нь зөвхөн гишүүдийнх байх уу?, бусад этгээдээс хандив авч болох уу, үндсэн зорилгоо хэрэгжүүлэх хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болох эсэх, татан буугдсан нөхцөлд үлдсэн хөрөнгийг хэрхэн зохицуулах вэ? гээд олон эргэлзээтэй асуудал хөндөгдөж байна.

Иймд Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийг бүхэлд нь шинэчлэх шаардлагатай байна.

Энэ бүгдийг нэгтгэн дүгнэхэд нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг мэргэжлийн холбоод, үйлдвэрчний эвлэлээс ялган тодорхойлж, хуулийн этгээдийн бие даасан төрлөөр тусгайлан бүртгэх нь чухал байна.

Түүнчлэн энэхүү бүртгэлээр дамжуулан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн гаргаж буй шийдвэрийг Захиргааны ерөнхий хуулийн хяналтад бүрэн хамруулах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

Мөн хуулиар тусгайлан эрх олгоогүй ч гишүүдээ болон тухайн салбар, чиглэлийн байгууллагуудыг төлөөлөн төртэй хэлэлцээр хийх эрхийг эрх зүйн бусад актаар олгосон байгууллагууд ч байна.

Тухайлбал, Монголын Үндэсний Олимпын хороо болон Монголын паралимпийн хороо нь БСШУС-ын сайдын 2016 оны А/31 дүгээр тушаалаар батлагдсан Үндэсний шигшээ баг бүрдүүлэх, тамирчдыг сонгон шалгаруулах журмын дагуу “шигшээ баг”-ийг бүрдүүлэх, тамирчдыг сонгон шалгаруулах бүрэлдэхүүнд тус тус оролцдог байна.

Үүнээс үзэхэд адил чиглэлийн зорилго, үйл ажиллагаа бүхий байгууллагуудыг төлөөлөх эрхийг хэрхэн тогтоох нь төрөөс ашгийн бус байгууллагатай хамтран ажиллах ажиллагаанд нэн чухал байна.

Иймд ТББ-уудын холбоо, нэгдэл зэргийн гишүүнчлэлийн тодорхой хувь хэмжээг харгалзах(салбарын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагын хэдэн хуийг гишүүнчлэлдээ хамруулсан байдал, хүлээн зөвшөөрөгдсөн болон төлөөлөх чадварыг харгалзах), улмаар төлөөллийн хувьд хүлээх эрх, үүргийг хуулиар тодорхойлох нь зүйтэй хэмээн дүгнэж байна.

➤ **Сан:**

Улсын бүртгэлийн мэдээллээр 2018 оны 1 дүгээр сарын байдлаар 1320 сан бүртгэгдсэн байна.⁹²

Иргэний хуульд “Сан”-г ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нэг хэлбэр байхаар хуульчилж, “нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээд” хэмээн тодорхойлсон байна.

Үүнээс үзэхэд сангийн үүсгэн байгуулагчдын зорилго нь нийгэмд тустай үйл ажиллагаанд нэгдсэн бөгөөд энэхүү зорилгоо хэрэгжүүлэх арга нь хөрөнгө төвлөрүүлэх явдал юм. Түүнчлэн сангийн хувьд бусад ТББ-аас ялгарах нэг онцлог нь гишүүнчлэлгүй байх бөгөөд санг үүсгэн байгуулагч нь санг удирдах эрх, үүрэггүй⁹³ байна.

Сангийн хувьд бусад ТББ-аас ялгаатай дараахь хэд хэдэн зохицуулалт Иргэний болон Төрийн бус байгууллагын тухай хуулиар үйлчилж байна⁹⁴:

Д/д	Сан	Бусад ТББ
1	Сангийн удирдах зөвлөл нь хандивлагч, дэмжигч, тэдгээрийн томилсон төлөөллөөс бүрдэнэ. ⁹⁵	Удирдах зөвлөлийн гишүүн хэн байхыг заагаагүй бөгөөд 5-аас доошгүй сондгой тооны гишүүдээс бүрдэнэ. ⁹⁶
2	Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа олон нийтэд түгээх үүрэгтэй. ⁹⁷	ТББ-ын үйл ажиллагаа нь олон нийтэд ил тод байх ба түүний гишүүд болон иргэд хэн ч тухайн байгууллагын тайлантай танилцаж болно. ⁹⁸ ТББ нь зохих журмын дагуу жилийн тайлан тэнцэлээ гаргаж ... татварын албанд өгнө. ⁹⁹ ТББ-д өргөсөн хандивыг хэрхэн зарцуулсан тухай хандивлагчдад тайлагнах эсэхээ тэдгээртэй байгуулсан гэрээнд тусгана. ¹⁰⁰

⁹² Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэл. 2018 оны 1 сар.

⁹³ Монгол Улсын Иргэний хуулийн шинэжлэх ухааны тайлбар. 63 дахь тал.

⁹⁴ Иргэний хуулийн 37, 38 дугаар зүйл, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 25 дугаар зүйл.

⁹⁵ Иргэний хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг.

⁹⁶ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг.

⁹⁷ Иргэний хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг.

⁹⁸ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.

⁹⁹ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

¹⁰⁰ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

3	<p>Дараахь зориулалтаар бусдад мөнгө хандивлаж болно:¹⁰¹</p> <p>1/төрийн бус байгууллагаас нийгмийн тусын тулд явуулж байгаа ажлыг дэмжих;</p> <p>2/сангийн зорилгод нийцсэн төслийг төрийн байгууллагаас хэрэгжүүлэх;</p> <p>3/сангийн зорилгод нийцсэн бол хувь хүний сургалтын төлбөр болон түүнтэй холбогдох бусад зардал, хувь хүнээс явуулж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлыг санхүүжүүлэх;</p> <p>4/иргэдийн нийгэмд тустай үйл ажиллагааг урамшуулах.</p>	<p>ТББ нь орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна. ¹⁰²</p> <p>ТББ-ын орлогоос иргэн, ААН, байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөх зэргийг хориглоно.</p>
	<p>Сан нь жил бүр олсон ашгийнхаа 50-иас доошгүй хувийг дүрэмд заасан үйл ажиллагаандаа зарцуулна.¹⁰³</p>	<p>ТББ-ын орлого нь нь дараахь эх үүсвэрээс бүрдэж болно:¹⁰⁴</p> <p>...3/дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого</p>
4	<p>Санг татан буулгах тухай шийдвэрийг удирдах зөвлөлийн нийт гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар гаргана. Татан буугдсан сангийн эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий санд шилжүүлэх бөгөөд хэрэв тийм сан байхгүй бол сангийн зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.¹⁰⁵</p>	<p>Төрийн бус байгууллагыг дүрэмд заасан зорилгоо бүрэн хэрэгжүүлж дууссан болон дүрэмд нь заасан бусад үндэслэлээр татан буулгаж болно. Ийнхүү татан буулгах тухай шийдвэрийг төрийн бус байгууллагын эрх барих байгууллага гаргана.¹⁰⁶</p> <p>Татан буугдах төрийн бус байгууллагын зохих төлбөрийг хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий төрийн бус байгууллагад шилжүүлэх, хэрэв тийм төрийн бус байгууллага байхгүй бол зорилгод нь нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.¹⁰⁷</p>

Энэхүү харьцуулалтаас үзэхэд сан нь жил бүр олсон ашгийн 50 –иас доошгүй хувийг тухайн жилдээ заавал зарцуулсан байх, мөн тодорхой зорилгоор мөнгө хандивлах, төлбөр төлөх, урамшуулах зэргээр эдийн засгийн дэмжлэгийг иргэд, байгууллагад үзүүлж болохоор байна.

Мөн тухайн сан нь олсон ашгийнхаа 50-иас доошгүй хувийг үндсэн үйл ажиллагаандаа зарцуулсан эсэхийг хэн хянах нь тодорхойгүй, зарцуулаагүй нөхцөлд хэрхэн шийдвэрлэх болон санд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байна.

Түүнчлэн удирдах зөвлөлд хандивлагчийг заавал оролцуулахаар заасан нь хүндрэлтэй төдийгүй сан нь өөрөө хэрэгжүүлэгч биш санхүүжүүлэгч байна гэсэн агуулгаар ойлгоход хүргэж байна.

¹⁰¹ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

¹⁰² Төрийн бус байгууллагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

¹⁰³ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

¹⁰⁴ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйл.

¹⁰⁵ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

¹⁰⁶ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйл.

¹⁰⁷ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйл.

Мөн Иргэний хуулийн 38 дугаар зүйлд санг татан буулгах журмыг тодорхойлсон бөгөөд сангийн үлдсэн хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий этгээдэд шилжүүлэх, хэрэв **тийм байгууллага байхгүй бол төрийн өмчлөлд шилжүүлэхээр** заажээ.

Гэтэл Төрийн бус байгууллагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэгт "...Татан буугдсан сангийн эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий санд шилжүүлэх бөгөөд **тийм сан байхгүй бол сангийн зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.**" гэжээ.

Үүнээс үзэхэд татан буугдсан сангийн үлдсэн хөрөнгийг төрийн өмчлөлд шилжүүлэх нь тухайн хөрөнгийг сангийн зорилгод нийцсэн хэлбэрээр зарцуулах эсэх, түүний хэрэгжилтэд хэрхэн хяналт тавих нь тодорхойгүй, мөн төрд шилжүүлэхгүйгээр сангийн зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна гэвэл хэн, хэрхэн хэрэгжүүлэх вэ? гэсэн олон асуулт хөндөгдөж байна.

Эдгээр асуудал нь зөвхөн татан буугдах сангийн хөрөнгийн хувьд ч бус бусад ТББ-ын хувьд ч хөндөгдөж байна.

Ийнхүү **ашгийн бус байгууллагуудын төрөл, тэдгээрт хамааралтай эрх зүйн зохицуулалтыг нэгтгэн дүгнэвэл** эдгээр байгууллагуудад ашгийн бус байгууллагынх нь хувьд тавигдах нийтлэг шаардлагыг Төрийн бус байгууллагын тухай хуулиар, харин тусгай чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн хувьд тавигдах шаардлагыг холбогдох салбар хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл тухайн төрлийн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамаарч тавигдах шаардлага, хяналтыг нарийвчлан хуульчлаагүйгээс байгууллагын үйл ажиллагаанд бүхэлд нь бус зөвхөн тусгай зөвшөөрлөөр хэрэгжүүлдэг хэсэгт нь хяналт төвлөрөх зэргээр хяналтын гадна үлдэхэд хүрч байна

Тухайлбал, хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд тусгайлсан зохицуулалтгүйгээс аливаа хэлбэрээр хараат бус байх нөхцөл нь алдагдах төдийгүй иргэдийн мэдээлэл авах эрхэнд ч сөргөөр нөлөөж болохуйц нөхцөл байдал үүсээд байна.

Засгийн газар нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа бөгөөд тус төсөлд хуулийн этгээдийн бүртгэлийн төрөлд дараахь байдлаар өөрчлөлтийг оруулахаар тусгасан байна:

Хуулийн этгээдийн төрөл:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд /2015 он/	Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд /2018 он /
--	---

<p>8.1.Улсын бүртгэлийн байгууллага дараах хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэнэ: 8.1.1.нөхөрлөл; 8.1.2.компани; 8.1.3.хоршоо; 8.1.4.төрийн бус байгууллага; 8.1.5.төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар; 8.1.6.төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар; <u>/салгаж бүртгэхээр өөрчилсөн/</u> 8.1.7.шашны байгууллага; 8.1.8.хэвлэл мэдээллийн байгууллага; <u>/хасагдсан/</u> 8.1.9.нийтийн эрх зүйн хуулийн этгээд; <u>/хасагдсан/</u> 8.1.10.гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж; <u>/хасагдсан/</u> 8.1.11.соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн байгууллага; <u>/хасагдсан/</u> 8.1.12.гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар.<u>/илүү тодорхой болгосон/</u></p> <p>8.2.Энэ хуулийн 8.1.6-д Засгийн газар хоорондын байгууллага, олон улсын байгууллага болон Засгийн газрын тусгай сан, комисс, хороо, үндэсний зөвлөл хамаарахгүй.</p>	<p>7.1.Улсын бүртгэлийн байгууллага дараах хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэнэ: 7.1.1.нөхөрлөл; 7.1.2.компани; <u>7.1.3.холбоо /төрийн бус байгууллагыг нийтлэгээр хамруулсан/;</u> <u>7.1.4.сан; /нэмэгдсэн/</u> 7.1.5.хоршоо; 7.1.6.шашны байгууллага; 7.1.7.төрийн байгууллага, албан газар; 7.1.8.улсын төсөвт үйлдвэрийн газар; 7.1.9.аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар; 7.1.10.гадаадын хуулийн этгээд <u>/компани, нөхөрлөл/-ийн төлөөлөгчийн газар;</u> <u>7.1.11.олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын олон улсын байгууллага. /нэмэгдсэн/</u></p> <p>7.3.Олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын олон улсын байгууллагыг бүртгэх журмыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p>
--	--

Иймд хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэлд хуулийн этгээдүүдийг эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр нь ангилж бүртгэх нь бус төрлөөр нь бүртгэх, мөн зарим нэг онцлог төрлийг тусгайлан авч үзэж байгаа нь(шашны байгууллага) бүртгэлийн хяналтыг хэрэгжүүлэхээр зохицуулж байгаа нь сайшаалттай боловч нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг тусгайлан бүртгэхгүй байхаар зохицуулсан нь учир дутагдалтай байна.

Харин үйл ажиллагаанд тавих хяналтыг бүртгэлийн байгууллага бус салбарын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага хариуцах асуудлыг нэгдсэн байдлаар зохицуулах нь зүйтэй байна.

Жишээ болгож гадны зарим орны ашгийн бус хуулийн этгээдийн төрлийн авч үзвэл улсын бүртгэлийн байгууллага нь үйл ажиллагааны чиглэлээр нь бус ашгийн болон ашгийн бус хуулийн этгээдээр голлон бүртгэдэг бөгөөд ашгийн бус байгууллагын үйл ажиллагааны чиглэлээс хамаарч салбарын хуулиудад тусгайлсан шаардлага, хяналтыг зохицуулдаг байна.

➤ Оросын холбоон улс:

Иргэний хуульд хуулийн этгээд нь ашиг олохыг үйл ажиллагааныхаа зорилго болгосон ашгийн төлөө, эсхүл ашгаасаа ногдол ашиг хуваарилдаггүй ашгийн төлөө бус байж болохоор заасан ба хуулийн этгээдийн төрлүүдийг жагсаасан.

Ашгийн төлөө бус гэдэгт хэрэглэгчдийн холбоо /СӨХ г.м/, нийтийн байгууллага /улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл г.м/, иргэний хөдөлгөөн, холбоо /ажил олгогчдын холбоо, мэргэжлийн холбоод, ашгийн төлөө бус нөхөрлөл г.м/, өмчлөгчдийн нөхөрлөл, казакчуудын нийгэмлэг, ОХУ-ын цөөнх уугуул иргэдийн холбоо, сан, институт /Шинжлэх ухааны академи г.м/, өөрөө өөрийгөө удирдах ашгийн төлөө бус байгууллага, шашны байгууллага, өмгөөлөгчдийн танхим, төрийн өмчит корпораци, нотариатчдын танхим зэргийг багтаасан байна.

➤ Филиппин

Филиппиний хууль нь АНУ-ын хуулиас эх авсан хуулбарласан шинжтэй байдаг. Тус улсын Иргэний хуулийн дагуу дараахь этгээд нь хуулийн этгээдийн эрхтэй байна:

1/ Төр болон түүний харьяа нэгжүүд,

2/ нийтийн эрх ашиг, зорилгын төлөө хуулиар байгуулагдсан компани, институт, хуулийн этгээд,

3/ хувийн эрх ашиг эсвэл хуулиар зөвшөөрөгдсөн хуулийн этгээдийн зорилгын төлөө компани, нөхөрлөл, холбоо.

1, 2 дугаарт заасан хуулийн этгээдийг хуулиар байгуулна. Харин 3 дугаарт заасан хуулийн этгээдийг Хуулийн этгээдийн тухай хуулиар зохицуулж байна.

Хуулийн этгээдийн тухай хуульд хуулийн этгээд нь хувьцаатай (ашгийн төлөө), хувьцаагүй (ашгийн төлөө бус) гэсэн 2 төрөл байхаар заасан ба хуулийн этгээдийг бүртгэх байгууллагад бүртгүүлснээр эрх үүснэ гэж заасан.

Хувьцаатай хуулийн этгээд гэдэгт хөрөнгөө хувьцаанд хувааж, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах байгууллагыг ойлгох ба үүнээс бусдыг нь хувьцаагүй хуулийн этгээд гэнэ.

Харин хувьцаагүй хуулийн этгээд нь үйл ажиллагаанаасаа олох орлогоо гишүүд, төлөөлөгч, ажилтандаа хуваарилдаггүй. Орлогыг зөвхөн байгууллагын үйл ажиллагааныхаа зорилгыг биелүүлэхэд ашиглана.

Хувьцаагүй хуулийн этгээд нь буяны, шашны, боловсролын, мэргэжлийн, соёлын, нийтлэг сонирхлын, утга зохиолын, шинжлэх ухааны, нийгмийн, ард иргэдэд үйлчлэх болон худалдаа, үйлдвэрлэл, газар тариалан зэрэг зорилгоор, эсхүл танхим зэрэг төрөл бүрийн нэрээр зохион байгуулагдаж, бүртгэгдэж болно.

108

➤ Япон

¹⁰⁸ Securities and exchange commission <http://www.sec.gov.ph/forms-and-fees/primary-registration/>

Иргэний хуулиараа боловсрол, урлаг, буяны, мөргөл, шашны зэрэг нийтийн ашиг сонирхлын төлөө ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулахаар эрх бүхий этгээдийн зөвшөөрөлтэйгээр холбоо, сан байгуулахыг зөвшөөрдөг байна.

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хэлбэр олон төрөл байж болно. Шашны байгууллагын тухай хуульд(1951 он) шашны үйл ажиллагаа /шашны боловсрол, номлол, зан үйл, ёслол/-г шашны байгууллага эрхэлнэ гэжээ.

Шашны байгууллага нь энэ хуулийн дагуу байгуулагдах ба оршин байгаа газрын Засаг даргаас болон Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайдаас зөвшөөрөл авна.

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яаманд 10-аас доошгүй 20-оос дээшгүй хүний бүрэлдэхүүнтэй Шашны байгууллагын зөвлөл (цалин, олговоргүй) ажиллана. Уг зөвлөл нь бүртгэлийн асуудлаар дүгнэлт гаргаж сайдад танилцуулах болон хуульд заасан бусад эрх, үүргийг эдэлдэг байна.

➤ Бүгд Найрамдах Солонгос улс

Хуулийн этгээдийн ашгийн төлөө болон ашгийн төлөө бус гэж ангилна.

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг 4 ангилна.¹⁰⁹ Шинжлэх ухаан, шашин, буяны, урлаг, нийгмийн харилцаатай холбоотой холбоо, сан болон ашгийн төлөө бус аж ахуйг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр хуулийн этгээдийн эрхтэй байгуулж болно гэж Иргэний хуульд заасан.

Дээр дурдсанчлан шашин нь нийтийн ашиг сонирхлын байгууллагын хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна.

Нийтийн ашиг сонирхлын байгууллагын үүсгэн байгуулалт, үйл ажиллагааны тухай хуулиар сургалтын төлбөрийн тэтгэлэг, тусламж, судалгааны санхүүжилт, нийгмийн нийтлэг ашиг сонирхлын төлөөх шинжлэх ухаан, буяны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулахаар бүртгэгдсэн холбоо, сангийн үйл ажиллагааг зохицуулсан.

Иргэний хуульд заасан нийтийн ашиг сонирхлын байгууллагыг бүртгүүлэх өргөдлийг эрх бүхий байгууллага хүлээн аваад санг оруулсан хөрөнгөөрөө үйл ажиллагаагаа тогтвортой явуулах чадвартай гэж үзсэн нөхцөлд, холбоог гишүүнчлэлийн хураамж, хандив зэргээр үйл ажиллагаагаа тогтвортой явуулах чадвартай гэж үзвэл бүртгэнэ.

Хэрвээ санхүүжилтийн арга нь аж ахуйн үйл ажиллагаа бол үүнийг дүрэмдээ тодорхой тусгаж төлөвлөх шаардлага тавьдаг ба илүү нарийвчилсан харилцааг Ерөнхийлөгчийн зарлигаар зохицуулна.

Нийтийн ашиг сонирхлын байгууллага нь 5-аас доошгүй 15-аас дээшгүй тооны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, 2 аудитортой байх ба уг тоог бүртгэх байгууллагын зөвшөөрснөөр өөрчилж болно.

¹⁰⁹ Companies are grouped into four categories: hapmyong-hwesa (partnership companies), hapja-hwesa (limited partnership companies), joosik-hwesa (stock companies) and yuhan-hwesa (limited liability companies).

Удирдах гишүүдээр ажиллахыг хориглосноос бусад хүнийг бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр гүйцэтгэх захирлаар томилно.

Удирдлагын болон ажилчдын тоог мөн бүртгэх байгууллагаас зөвшөөрсөн тоотой байлгана.

Ашгийн төлөө бус төрийн бус байгууллагыг дэмжих хуульд нийтийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахаар хувийн хэвшлийн ашгийн төлөө бус төрийн бус байгууллага байгуулж болохоор заасан.

Уг байгууллага тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд нийтийн эрх ашгийн төлөө төрийн захиалгат ажлыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр хийнэ.

Ашгийн төлөө бус байгууллагыг тусгайлан хууль баталж хуулийн этгээдийн эрхтэй болгодог практик байна.

Жишээ нь: Эрдэмтэд, инженер нарын харилцан туслалцааны холбооны тухай, БНСУ-ын үндэсний Улаан загалмайн байгууллагын тухай, Иргэний агаарын тээврийг хөгжүүлэх холбоог байгуулах тухай, Төрд онцгой гавьяатай зүтгэсэн хүмүүсийн төлөө холбоо байгуулах тухай хуулиар 9 холбоог нэр дурдаж байгуулсан¹¹⁰.

Солонгост төрийн бус байгууллагуудыг заавал бүртгүүлэхийг шаарддаггүй /хуулийн этгээдийн эрхгүй/ ба үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-ын ойролцоогоор 54 хувь нь бүртгэлгүй байдаг гэсэн судалгаа байна.

ХОЁР.АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ӨМЧИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Иргэний хуульд өмчийн хэлбэрийг нийтийн болон хувийн өмч хэмээн ангилсан¹¹¹ бөгөөд нийтийн болон хувийн өмч нь холимог хэлбэрээр байж болно¹¹²

¹¹⁰ purpose of this Act is to help persons who have performed distinguished services for the State ... by establishing the Korea Disabled Veterans Organization, the Korea War Veterans Bereaved Families Association, the Korea War Widows Association, the Korea Liberation Association, the April 19 Revolution Association, the Association of Bereaved Families of the April 19 Revolution Victims, the Association of Persons of Distinguished Services in the April 19 Revolution, the Association of Korean Student Volunteer Soldiers from Japan, and the Korea Military Merit Awardees Association

Солонгос http://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=38884&lang=ENG
Япон [file:///C:/Users/Amarmurun/Downloads/s26Aa001260206en5.0_h18A50%20\(1\).pdf](file:///C:/Users/Amarmurun/Downloads/s26Aa001260206en5.0_h18A50%20(1).pdf)
<http://www.moj.go.jp/content/000056024.pdf>

Орос <http://base.garant.ru/10164072/510567bc799b499f450a4638e59966a6/#friends>
https://www.wto.org/english/thewto_e/acc_e/rus_e/WTACCRUS48A5_LEG_119.pdf

Филиппин http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=225733#LinkTarget_253

¹¹¹ Иргэний хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэг.

¹¹² Иргэний хуулийн 99 дүгээр зүйлийн 99.4 дэх хэсэг

гээд нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн хэлбэртэй¹¹³, хувийн өмч нь иргэний болон дундын хэлбэртэй¹¹⁴ байна хэмээн тодорхойлсон.

Төрийн бус байгууллагын тухай хуульд зааснаар ТББ-ын орлого нь гишүүний татвар, хандив, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого, зээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгөөс бүрдэнэ гэжээ.

Эдгээр зохицуулалтаас дүгнэхэд ашгийн бус байгууллагын өмчийн эх үүсвэр нийтийн болон хувийн, түүнчлэн холимог хэлбэрийн аль аль хэлбэрээр байж болох боловч гахцхүү зорилгод заасан үйл ажиллагаанд зарцуулагдах бөгөөд түүнээс ашиг хуваарьлахыг хориглосон¹¹⁵ байна.

Ашгийн бус хуулийн этгээдийн хувьд татан буугдсан нөхцөлд хөрөнгийг адил чиглэл бүхий байгууллагад шилжүүлэх, хэрэв тийм байгууллага байхгүй бол төрийн өмчлөлд шилжүүлэхээр зохицуулсан байна.

Өөрөөр хэлбэл, ашгийн бус байгууллагын үүсгэн байгуулагчид, гишүүд, дэмжигчид нь тухайн хуулийн этгээдийн тусгайлсан хөрөнгийн хувьд эд хөрөнгийн аливаа эрх эдлэхгүй бөгөөд тухайн хуулийн этгээдэд оруулсан хөрөнгөнөөс ногдол ашиг хүртэх, татан буугдсан нөхцөлд өөрт оногдох хэсгээ буцаан авах эрхгүй байдаг.

Харин хуулийн этгээдийн эрхгүй ашгийн бус байгууллагын хувьд онцлон хуульчилсан тодорхой зохицуулалт байхгүй, харин хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын нийтлэг зохицуулалтаас үзэхэд гишүүд тэнцүү, эсхүл татварын хэмжээ болон үүргийг гүйцэтгэлээс хамаарч ялгаатай байдлаар хуваахаар байна.

Гэвч ашгийн бус байгууллагын өмчийн эрх зүйн зохицуулалтанд анхаарах шаардлагатай хэд хэдэн асуудал байхаас гадна хууль хоорондын зөрчил үүсгэсэн зохицуулалтууд ч байсаар байна.

Тухайлбал, Иргэний хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэгт сан татан буугдсан тохиолдолд үлдсэн хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий этгээдэд шилжүүлэх, **тийм байгууллага байхгүй бол төрийн өмчид шилжүүлэхээр заасан бол Төрийн бус байгууллагын тухай хуулийн 25 дугаар зүйл буюу Сангийн тусгай зохицуулалт гэсэн зүйлийн 3 дахь хэсэгт “... татан буугдсан сангийн эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий санд шилжүүлэх бөгөөд хэрэв тийм байгууллага байхгүй бол сангийн зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.”** гэсэн байна.

¹¹³ Иргэний хуулийн 99 дүгээр зүйлийн 99.2 дахь хэсэг.

¹¹⁴ Иргэний хуулийн 99 дүгээр зүйлийн 99.3 дахь хэсэг

¹¹⁵ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

Түүнчлэн Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 36.6 дэхт хэсэгт “Сүм хийд иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаархи хуулийн заалтыг мөрдөнө”, мөн зүйлийн 36.3-т “Холбоо, сангийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно” гэсэн боловч өнөөг хүртэл Сангийн тухай бие даасан хууль гараагүй тул шашны байгууллагын хөрөнгө, түүний зарцуулалтыг Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 11 дүгээр зүйл болон Иргэний хуулийн 37 дугаар зүйлд зааснаар зохицуулагдахаар байна.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Сүм хийд үйл ажиллагаагаа бүрмөсөн зогсоох тохиолдолд үүсгэн байгуулагчид нь анх оруулсан эд хөрөнгөө нэхэмжилбэл тэдгээрт хөрөнгийг нь олгож, хөрөнгийн бусад хэсгийг лам санваартнуудын саналыг харгалзан аль нэгэн сүм хийдэд, боломжгүй бол төрийн мэдэлд шилжүүлнэ.” гэжээ.

Шашны байгууллагыг татан буугдах үед үүсгэн байгуулагч нь өөрт оногдох хөрөнгийг нэхэмжилж болох бөгөөд ямар нэгэн нэмэгдэл ашиг тооцохгүйгээр анх оруулсан хөрөнгийн хэмжээгээр¹¹⁶ тооцон нэхэмжлэх эрхтэй байхаар хязгаарлан зохицуулсан байна. Гэтэл шашны байгууллага нь ашгийн бус, нийтийн сайн сайхны төлөө үйлчилдэг байгууллага учраас үүсгэн байгуулагч нь шашны байгууллагад шилжүүлсэн эд хөрөнгийнхөө хувьд өмчлөх эрхээ хадгалах нь хууль зүйн агуулгын хувьд зөрчилдөөнтэй юм.

Өөрөөр хэлбэл Иргэний хуульд зааснаар сүм хийд нь иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаарх хуулийн зохицуулалтыг мөрдөх тул тус хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэгт зааснаар татан буугдсан тохиолдолд үүсгэн байгуулагчдад хөрөнгийг буцаан олгох зохицуулалт байхгүй, харин ижил төстэй зорилго бүхий этгээдэд, эсхүл төрийн өмчлөлд шилжүүлэхээр байна.

Үүнээс дүгнэхэд шашны байгууллагын өмчийн харилцааны эрх зүйн зохицуулалт үндсэн зорилгоос гажсан, зөрчилтэй байгаа нь сүм хийдийг нийтийн өмчийн хэлбэрээр бус хувийн өмч, өөр ашиг сонирхолын үүндээс байгуулах боломжийг бүрдүүлж байгааг анхаарах шаардлагатай юм.

Түүнчлэн төрийн бус байгууллагын тухай хуульд ТББ-ын орлогоос ногдол ашиг хуваарилах, иргэн, ААН, байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөх, УИХ, Ерөнхийлөгчийн болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчдэд эд хөрөнгө, хандив өгөхийг хориглосон байна.

Үнээс гадна тухайн байгууллагын чиг үүрэг, онцлогоос хамаарч хандив, санхүүжилт авах хүрээ болон үүсгэн байгуулагчдад тавих хязгаарлалтыг хуульчлан тогтоох нь зүйтэй байна.

¹¹⁶ Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг.

Статистикийн үндэсний хорооны Аж ахуйн нэгж, байгууллагын 2011 оны тооллогод дурдаснаар ТББ-ын нийт санхүүжилтийн 3.9 хувь нь гишүүний татвар, хандив 21.4, олон улсын санхүүжилт 67.7 хувьд, бусад эх үүсвэрээс 7 хувь гэж бүртгэгдэжээ.¹¹⁷ Харамсалтай нь үнээс хойш харьцуулахуйц мэдээлэл гараагүй байна.

ТББ-уудын дунд хийсэн судалгааны хүрээнд нийгэмд үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 10 ТББ-ын төлөөлөлтэй уулзахад тэдний үйл ажиллагааны санхүүжилтийн дөнгөж 5-10% нь төрөөс (төрийн чиг үүргийг гэрээлэх тохиолдолд), 90-100 % гадаадын донор болон Олон улсын байгууллагын төслийн санхүүжилт байдаг байна.¹¹⁸

Харин улс төрийн бодлогын асуудлаар ажилладаг буюу хүний эрх, эмэгтэйчүүдийн эрх, байгаль орчин хамгаалах, авлигын эсрэг зэрэг зорилго бүхий ТББ-уудын хувьд бараг бүхэлдээ гадны донор байгууллагын санхүүжилтээр ажиллаж байна.¹¹⁹

Гэтэл хэвлэл мэдээлэл, шашны зэрэг байгууллагын хувьд санхүүжилтийн талаархи мэдээлэл дутмаг бөгөөд гадаадаас санхүүжилтийн хувьд хараат байх нь илүү эрсдэлтэй ч хуулиар хориглосон зохицуулалтгүй байхгүй байна.

Тухайлбал, Манай улсад ажиллаж байгаа Христийн шашны чиглэл бүхий шашны байгууллагуудын дийлэнх нь БНСУ-ын санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж байна. Мөн исламын шашны байгууллагад санхүүжилт хийх зорилготой хэмээн их хэмжээний бэлэн мөнгө улсын хилээр нэвтрүүлэх оролдлого хийж байсан тохиолдол ч бүртгэгдсэн байна.¹²⁰

Иймд ашгийн бус байгууллагуудын төрөл, үйл ажиллагааны чиглэлээс хамаарсан санхүүжилт, тэр дундаа гадны болон ашиг сонирхол, нөлөөллийн шалгаанаар санхүүжүүлэх болон үүсгэн байгуулагчдад тавих хязгаарлалт нэн чухал байна.

Энэ чиглэлийн хязгаарлалтыг бусад орнууд ч эрх зүйн хүрээнд түгээмэл зохицуулдаг байна. Тухайлбал, ОХУ-ын хуулиас үзэхэд шашны байгууллагыг үүсгэн байгуулагч нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн байж болохгүй бөгөөд 18 насанд хүрсэн, тухайн орон нутагт тогтвор суурьшилттай амьдарч байгаа ОХУ-ын иргэн байхаар заасан байна.

ГУРАВ. АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГАД ТАВИХ ХЯНАЛТ

¹¹⁷ Статистикийн үндэсний хорооны мэдээлэл. 2012 он.

¹¹⁸ Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчлэл: Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан. ХЗДХЯ, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “иргэдийн оролцоо II” төсөл 2017он.

¹¹⁹Center for Citizens' Alliance (former CEDAW Watch). State of Civil Society in Mongolia (2004-2005) CIVICUS Civil Society Index Report for Mongolia, 63-70

¹²⁰ Цагдаагийн байгууллагын танилцуулга. 2017.11.08

Төрийн бус байгууллагын тухай хуульд зааснаар ашгийн бус байгуулагад тавих хяналтыг үйл ажиллагааны болон санхүүгийн, дотоод болон хөндлөнгийн, салбарын болон хууль хяналтын байгууллагаас тавих хяналт гэж ангилж болох юм.

Үйл ажиллагааны хяналт: ТББ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хяналтыг төрийн болон салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч байгууллага, улсын бүртгэл хариуцсан байгууллагаас хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Боловсролын байгууллагын хувьд боловсролын үйл ажиллагаатай холбоотой хяналтыг БСШУЯ болон МХЕГ, ТББ-ынх нь хувьд ОӨУБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар тус тус хариуцаж байна.

Гэвч Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас тавих хяналт сул төдийгүй салбарын хяналт шалгалт нь зөвхөн тусгай зөвшөөрөлтэй хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээгээр хязгаарлагдах тул дийлэнх ТББ-ууд хяналтын гадна үлдэж байна.

Хэдийгээр Төрийн бус байгууллагын тухай хуулиар ТББ-ууд нь үйл ажиллагааныхаа тайланг жил бүр бүртгэлийн газарт гаргах үүрэгтэй хэдий ч Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар улсын бүртгэлийн байгууллага нь ийнхүү ТББ-ын үйл ажиллагаанд нь хяналт тавих чиг үүргийг хүлээлгэсэн зохицуулалт байхгүй байна.

Төрийн бус байгууллагын тухай хуулийн зохицуулалтын дагуу ТББ-аас цөөн хэсэг нь тайланг ирүүлдэг боловч бүртгэлийн байгууллагаас ч энэхүү тайлангийн мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломж муу, зорилгодоо нийцээгүй, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байгааг тогтоож татан буулгах асуудлыг шүүхээр шийдвэрлүүлж байсан тохиолдол алга байна.¹²¹

Үйл ажиллагааны тайланд

1/төрийн бус байгууллагын хаяг;
2/үйл ажиллагааны тухай товч мэдээлэл;
3/жилийн орлого, зарлага;
4/700.000 төгрөгнөөс дээг хандив буюу өвийн хөрөнгө өгсөн байгууллага, иргэний нэр, зүйлсийн жагсаалт(хандивын, дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагааны, өвлүүлсэн эд хөрөнгийн гэсэн ангилалаар);

5/удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирлын нэр, хаяг.

Үйл ажиллагааны тайланд тусгах эдгээр мэдээллээс ТББ-ын нэр, хаяг, гүйцэтгэх удирдлагын нэр, хаяг нь хуулийн этгээдийн хувийн хэрэгт тэмдэглэгдэх

¹²¹ Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан. ХЗДХЯ, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “иргэдийн оролцоо II” төсөл 2017он.

мэдээлэл¹²² бөгөөд мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор энэ талаар улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэх үүрэгтэй байна.¹²³

Иймд эдгээр мэдээлэл нь жилийн эцсийн тайланд тусгах нь төдийлөн ач холбогдолтой биш бөгөөд жилийн орлого, зарлага, хандивлагчдын нэрс, хандивын зүйлс нь ч үйл ажиллагааны хяналтанд чухал биш юм.

ТББ-ын үйл ажиллагаанд тавих хяналт нь дүрмийнхээ зорилгод нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэх(ТББ-ын дүрмэнд байгууллагын зорилгыг тусгахаас бус үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тусгахыг хуулиар шаардаагүй байна¹²⁴), хууль тогтоомжийг сахин биелүүлж байгаа эсэхийг хамрах тул хяналтыг бүртгэлийн байгууллага бус салбарын болон тухайн чиглэлийн ТББ-уудын холбоо, нэгдэл хариуцах нь илүү ач холбогдолтой байж болох юм.

Өөрөөр хэлбэл, ТББ-ын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт(гишүүдийн, дотоод хяналтын нэгж, тухайн чиглэлээрх ТББ-уудын нэгдэл, холбоод), олон нийтийн хяналтыг өндөржүүлэх шаардлагатай байна.

Нийтлэг хяналтын зохицуулалтаас гадна онцлогоос хамаарч шашны байгууллага, хэвлэл мэдээлэл, улс төрийн нам, боловсролын зэрэг байгууллагуудад тусгай хяналтыг хэрэгжүүлэх шаардлага бий болдог.

Иймд хяналтын онцлогт нийцүүлсэн зохицуулалт, хэрэгжүүлэгч байгууллагуудын эрх хэмжээг салбарын хуулиудад тодорхой хуульчлах, түүнчлэн гэмт хэрэг, зөрчил болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлигатай тэмцэх зэрэг онцлог хяналтыг хэрэгжүүлэх боломжийг эрх зүйн зохицуулалтын хүрээнд сайжруулахад анхаарах шаардлагатай байна.

Харин хуулийн этгээдийг шинээр байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон хуульд заасны дагуу түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх асуудлыг улсын бүртгэлийн байгууллага хариуцдаг байдлыг хэвээр хадгалах нь зүйтэй байна.

Санхүүгийн хяналт: Төрийн бус байгууллагын тухай хуулиар ТББ нь жилийнхээ тайлан тэнцлийг гаргаж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор татварын албанд өгөх үүрэгтэй байна.¹²⁵

ТББ нь ашгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг тул үндсэн үйл ажиллагаатай холбогдуулан орлогын албан татвар төлдөггүй боловч үндсэн зорилгоо хэрэгжүүлэх хүрээнд эрхэлж байгаа аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогоос татвар төлөх үүрэгтэй байна.

¹²² Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.3, 11.1.10 дахь заалт.

¹²³ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн

¹²⁴ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйл.

¹²⁵ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

Гэтэл ашгийн бус байгууллага нь ААН-ийн орлогын албан татвар төлдөггүй тул татварын байгууллагын хяналтын гадна үлддэг. Жишээ нь, 2014 оны мэдээллээр Нийслэлд зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байсан сүм хийдийн 25.4% нь “санхүүгийн тайлан тэнцэл огт гаргадаггүй” гэж мэдээлсэн бөгөөд эдгээр байгууллагын 37.5% нь хэвийн үйл ажиллагаатай байна.¹²⁶

Гэвч санхүүгийн хяналт нь зөвхөн татвараа үнэн зөв тодорхойлж, бүрэн төлж барагдуулж буй эсэхэд бус санхүүжилтийн эх үүсвэр, түүний хууль ёсны эсэх болон зарцуулалт нь хуульд заасан зохих журмын дагуу байгаа эсэхэд давхар чиглэгдэх ёстой.

Хэдийгээр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл 20 сая төгрөг түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийх тохиолдолд Санхүүгийн мэдээллийн албаны хяналтанд хамруулахаар заасан байна.

Дээрх үндэслэлээр ашгийн байгууллагын санхүүжилттэй холбоотой тохиолдлыг илрүүлж шалгасан талаарх мэдээлэл тодорхойгүй байна.

Харин иргэдийн дунд хийсэн ярилцлагын дүнгээс харахад судалгаанд хамрагдагсдын 70 хувь нь гадны санхүүжилт бүхий ТББ-ууд нь санхүүгийн хувьд маш их чадвартай хэмээн дүгнэсэн байна.¹²⁷

Гэтэл энэ чиглэлийн хяналт сул байгаагаас ТББ-ууд нь улс төрийн үйл ажиллагаанд оролцох, гадны үзэл суртал, соёл, хандлагын шахалтанд өртөх(ТББ-уудын санхүүжилт бүхэлдээ гадны донор байгууллагуудаас хараат байгаа нь сонголт хийх болон харилцан хэлэлцээр хийх боломжгүй болгох, санхүүжилтээр дамжуулан үйл ажиллагаанд нь нөлөөлөх боломжтой нөхцөл байдлыг хамруулсан болно), улмаар мөнгө угаах, хууль бус үйл ажиллагааг дэмжих, санхүүжүүлэхэд оролцох зэрэг эрсдэл бий болох боломжтой юм.

Энэ хүрээнд хөндөх бас нэг асуудал бол төрөөс ашийн бус байгууллагад үзүүлэх үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг юм.

Ашгийн бус байгууллага нь иргэний нийгмийн төлөөлөл болж, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэгч болохын хувьд ашгийн төлөөх бизнесийн байгууллагаас ялгаатай бөгөөд ялангуяа нийгмийн хамгаалал, халамж, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, нийгмийн хэв журам, хүний эрхийг хангах, хамгаалах, олон нийтийг соён гэгээрүүлэх зэрэг бүх нийтийг хамарсан, нийтийн ач холбогдол бүхий салбарын үйлчилгээ үзүүлэх чиглэлд оролцдог байна.¹²⁸

¹²⁶ Нийслэлийн сүм хийд, шашны байгууллагын 2014 оны тооллогын тайлан.

¹²⁷ “Монгол Улс дахь шашны харилцааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал” судалгааны тайлан. Хууль сахиулахын их сургууль. 2017 он

¹²⁸ Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх асуудал: Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан.ХЗДХЯ.2017 он

Өөрөөр хэлбэл, төр болон ашгийн бус байгууллагын хамтын ажиллагаа нь нэг талаас нийгэмд тулгамдсан асуудлыг ил болгох, асуудлыг шийдвэрлэх шийдэл боловсруулах, хэрэгжүүлэх, зохион байгуулахад төдийгүй зардлыг хэмнэх, төрийн үйлчилгээг энгийн, шуурхай болгох, чанар, үр ашгийг дээшлүүлэх, захиргааны хүнд суртлыг халж, үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээг нэн тэргүүнд тавих, төрийн үйлчилгээг иргэдэд илүү ойртуулах зэрэг боломжийг бүрдүүлдэг давуу талтай байна.

Нөгөө талаас төр өөрийн чиг үүргээ ашгийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх нь дээр дурдсан үр дүнгээс гадна төрд дэмжлэг болж, нөхөж ажиллах, нийгэмд эерэг өөрчлөлтийг авчирахад нөлөөлж чадавхуйц чадавхитай үндэсний төрийн бус байгууллагыг хөгжүүлэх зорилгыг агуулдаг байна.

Манай улсын хувьд 1997 оны Төрийн бус байгууллагын тухай хуульд “ Төрийн байгууллага төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлж болно.”¹²⁹, “Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас гаргах шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саналыг нь үндэслэн төрийн бус байгууллагыг оролцуулж болно.”¹³⁰ гэж заасан бөгөөд Засгийн газрын 1995 оны 111 дүгээр тогтоолоор “Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх ерөнхий журам”-ыг баталсан байна .

Улмаар 1996 онд Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд¹³¹ төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр заасан бол, мөн салбарын асуудлыг зохицуулсан хуулиудад (нийт 30 орчим хуульд) төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх талаар зохицуулалтыг тусгасан байна.

Гэвч эдгээр хуулийн зохицуулалт нь тухайн чиглэлийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх талаар ерөнхий агуулга бүхий заалт байх бөгөөд гэрээлэх чиг үүрэг болон ашгийн бус байгууллагад тавих шаардлагыг хуулиар бус журмаар харилцан адилгүй тогтоосон, түүнчлэн урт хугацаанд хамтран ажиллах түншлэгчийг сонгох, тэдэнд төрийн бодлогоор дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хянах зэрэг харилцаа зохицуулалтгүй хэвээр байна.

Түүнчлэн төрийн зарим чиг үүргийг ашгийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэгтгэн үзэж, адилтган зохицуулж байна. Энэ нь үйлчилгээний чанарт тавигдах шаардлагыг хангаж байгаа тохиолдолд хувийн хэвшил болон төрийн бус байгууллагуудын аль нь ч байж

¹²⁹ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг.

¹³⁰ Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг.

¹³¹“Засгийн газар нь холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно”, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19.1 дэх заалт

болохоор боловч өнөөгийн манай нөхцөлд (төрөөс зөвхөн үйлчилгээний зардлыг санхүүжүүлдэг тул) төрийн бус байгууллагыг дэмжих тусгай зохицуулалт шаардлагатай юм.¹³²

Өнөөгийн парктикаас үзэхэд төр болон ашгийн бус байгууллагын хамтын ажиллагаа нь дийлэнх тохиолдолд гарын авлага, мэдээлэл боловсруулах, сургалт зохион байгуулах зэргээр нэг удаагийн шинжтэй үйл ажиллагааг хамаарсан бөгөөд гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээний хүрээ ихээхэн хязгаарлагдмал байна.

Эдгээр бэрхшээл нь гэрээгээр гүйцэтгүүлэх үйлчилгээний хүрээ тодорхойгүй, гэрээ байгуулах байгууллагад тавих шалгуурыг бизнесийн байгууллалтад адилтгасан, мөн салбар бүрт харилцан адигүй байдлаар тогтоодог, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул, зөвхөн санхүүгийн хяналтаар хязгаарласан зэргээс шалтгаалж үр ашгийг бодитоор үнэлж чадахгүйд хүрэх, улмаар төрөөс ашгийн бус байгууллагуудыг хөгжих, чадавхижуулахад дэмжлэг үзүүлэхэд ач холбогдол өгөхгүй байхад хүргэж байна хэмээн судалгаагаар дүгнэсэн байна.¹³³

Олон улсын практиктаас үзэхэд төрөөс зарим чиг үүргээ төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг бусад байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах хэлбэрээс ялган зохицуулж, тусгай зарчим, шалгуурыг тогтоодог байна.

Нөгөө талаар төрөөс ашгийн бус байгууллагад үзүүлэх дэмжлэгийн нэг хэлбэр болох татвар, хураамжийн хөнгөлөлтийн нэгдсэн бодлого байхгүй байна. Өөрөөр хэлбэл, ашгийн бус байгууллагууд нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлдөггүй боловч тухайн байгууллагын зорилго, үйл ажиллагааг дэмжигчдэд(нийгэмд тустай үйл ажиллагааг дэмжигч) татварын хөнгөлөлт үзүүлэх зохицуулалт туйлын хангалтгүй байна.

Тухайлбал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжсэн нэг сая хүртэлх хэмжээний төгрөгийг уг аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасч тооцохоор байна.¹³⁴

Үүнээс дүгнэхэд энэхүү дэмжлэг нь нийт төрийн бус байгууллагад төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ТББ-д ч хамаарахгүй байхаар байна.¹³⁵

¹³² Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчлэл: Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан. ХЗДХЯ, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “иргэдийн оролцоо II” төсөл 2017он.

¹³³ Мөн дээрх судалгаа.

¹³⁴ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсэг.

¹³⁵ Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчлэл: Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан. ХЗДХЯ, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “иргэдийн оролцоо II” төсөл 2017он.

Иймд нийгэмд тустай үйл ажиллагаа болон төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх харилцааг нарийвлчан тодорхойлж, эдгээрийг гүйцэтгэж буй ашгийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэгчдэд татвар, хураамжийн хөнгөлөлт олгох зэрэг тусгай зохицуулалт шаардлагатай юм.

ДӨРӨВ. АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГАД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Ашгийн бус байгууллага нь эрх зүйн харилцаанд оролцогчийнхоо хувьд өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээх, үүсэх үр дагаварыг бүрэн хариуцах үүрэгтэй бөгөөд иргэний эрх зүйн харилцааны(гэрээ, хэлцлийн үндсэн дээр) улмаас үүсэх үр дагаварыг гэрээ болон хуульд заасны дагуу өөрийн хөрөнгөөр хариуцна.

Харин 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуулиар хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан.

Эрүүгийн хуульд зааснаар хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, түүний ашиг сонирхлын төлөө заасан гэмт хэргийг өөрөө үйлдсэн¹³⁶, эсхүл шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч бусдаар гүйцэтгүүлсэн¹³⁷ нөхцөлд хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болохоор байна.

Хуулийн этгээдэд торгох ял оногдуулахаас гадна ял дээр нэмж эрх хасах, татан буулгах, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг оногдуулна.¹³⁸

Гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулах ял, албадлагын арга хэмжээ

Хариуцлага	Хэмжээ	Тайлбар
1 Торгох ял	10.000-400.000 нэгж	10.000.000-400.000.000 төгрөг
2 Эрх хасах	1-8 жил хүртэл	Нэг, эсхүл хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах, эсхүл эрхийг нь хасах
3 Татан буулгах албадлагын арга хэмжээ		Хуулийн этгээдийг татан буулгасан тохиолдолд хөрөнгө, орлогыг хураан авч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь гэмт хэрэг үйлдсэн бол салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгаж болно.
4 Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ	Гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх	Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.

¹³⁶ Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

¹³⁷ Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

¹³⁸ Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйл.

Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах бөгөөд торгох, эрх хасан шийтгэлээс¹³⁹ гадна шийтгэл дээр нэмж хөрөнгө орлого¹⁴⁰ болон зөрчил үйдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах¹⁴¹, хохирол, нөхөн төлбөрийг гаргуулах¹⁴² албадлагын арга хэмжээ авахаар заасан байна.

Зөрчил үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээ

Хариуцлага		Хэмжээ	Тайлбар
1	Торгох шийтгэл	100-200.000 нэгж	100.000 -200.000.000 төгрөг
2	Эрх хасах шийтгэл	эрхийг 3 сараас -2 жил хүртэл хязгаарлах, эсхүл зөвшөөрлийг хүчингүй болгох	Тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах шийтгэлийг торгох шийтгэл дээр нэмж оногдуулна.
3	Хөрөнгө орлогыг хураах, шилжүүлэх албадлагын арга хэмжээ	зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого	“Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж зөрчил үйлдэн олж авсан мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг арилжаалж бий болгосон бусад эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг түрээслэх, ашиглах замаар олсон бүх төрлийн орлогыг ойлгоно.
4	Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах албадлагын арга хэмжээ	зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, зэвсэг, хэрэгсэл	Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл гэдэгт зөрчил үйлдэхдээ ашигласан зэвсэг, хэрэгсэл, эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналга, зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг ойлгоно. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл нь зөрчил үйлдсэн хүний амьжиргааны эх үүсвэр болсон эд зүйл, хэрэгсэл бол тэдгээрийг хураахгүй.
5	Хохирол, нөхөн төлбөр гаргуулах албадлагын арга хэмжээ	учруулсан хохирол, нөхөн төлбөрийн хэмжээгээр	Зөрчлийн улмаас учирсан хохирол барагдуулах, хор уршгийг арилгах арга хэмжээнд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.

Хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага гарцаагүй байх зарчмыг хуульчилсан бөгөөд хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан хэдий ч дараахь нөхцөлд хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг шилжихээр Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан байна:

- бусад хуулийн этгээдтэй нийлүүлэн нэг хуулийн этгээд үүсгэсэн бол шинээр бий болсон хуулийн этгээдэд;
- бусад хуулийн этгээдэд нэгтгэсэн бол нэгтгэж авсан хуулийн этгээдэд;

¹³⁹ Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйл.

¹⁴⁰ Зөрчлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйл.

¹⁴¹ Зөрчлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйл.

¹⁴² Зөрчлийн тухай хуулийн 4.3 дугаар зүйл.

- хуваах, тусгаарлах замаар өөр хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол тухайн гэмт хэрэгт холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэн авсан хувь хэмжээгээр нь зохих хуулийн этгээдэд;
- хуулийн этгээд нь зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөгдөн зохион байгуулагдсан хуулийн этгээдэд;
- компани нь толгой компани, түүний үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлын үүднээс гэмт хэрэг үйлдсэн бол толгой компанид.

Харин хариуцлагаас зайлсхийх зорилгоор хуулийн этгээдийг санаатайгаар татан буулгасан тохиолдолд хариуцлагыг эд хөрөнгө хуваарилагдсан хувьцаа эзэмшигчдэд, үндэслэлгүйгээр аливаа хэлбэр, арга, хэрэгслээр эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг тухайн хуулийн этгээдээс шилжүүлэн авсан бол нэгдмэл сонирхолтой этгээд, эд хөрөнгийг хариу төлбөргүйгээр шилжүүлсэн бусад хуулийн этгээдээс нөхөн гаргуулахаар заасан байна.

Эрүүгийн хуулийн 9.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдийг татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.” гэсэн боловч тусгай ангид хуулийн этгээдэд татан буулгах албадлагын арга хэмжээг террори үйлдэх, террори үйлдэхэд бэлтгэхээс бусад тохиолдолд оногдуулах боломжгүй байна.

Гэтэл дээрхээс гадна нийгэмд илүү сөрөг үр дагавар бүхий гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдийг татан буулгах хариуцлага оногдуулах боломжгүй байна.

Тухайлбал, Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан мөнгө угаах гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол **хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж** нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр **торгох ял шийтгэхээр** хуульчилсан байна.

Үүнээс дүгнэхэд Эрүүгийн болон зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд ял, шийтгэл, албадлагын арга хэмжээ оногдуулахаар заасан боловч тусгай ангид хуулийн этгээдийг татан буулгах, эрхийг нь хасах хариуцлагыг заагаагүйгээс тухайн хуулийн этгээд торгуулийн мөнгийг төлөөд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжтой байна.

Мөн зөрчил үйлдсэн хуулийн этгээдэд эрх хасах шийтгэл оногдуулахдаа эрх хязгаарлах, эсхүл эрхийг нь хасахаар зааснаас бус тухайн хуулийн этгээдийг татан буулгах хариуцлага байхгүй байна.

Үүнээс гадна ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээдэд хариуцлагын хувьд ялгаатай байдлаар зохицуулах, өөрөөр хэлбэл, ашгийн бус хуулийн этгээдэд торгох хариуцлага гэхээс илүү эрх хасах, татан буулгах хариуцлагын төрлийн оногдуулах нь үр дүнтэй байж болохыг анхаарах шаардлагатай байна.

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсад ашгийн бус байгууллагатай холбоотой харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтын хүрээнд хийсэн энэхүү дүн шинжилгээгээр эдгээр байгууллагуудын бүртгэл, мэдээлэл хангалтгүй, үйл ажиллагаа болон санхүүжилтэнд тавих төрийн болон олон нийтийн хяналт сул байгаагаас үндсэн зорилгоо халхавчлан ашгийн үйл ажиллагаа явуулах, улс төрийн үйл ажиллагаанд оролцох, ашиг сонирхолын төдийгүй гадны соёл, хандлага, харгис үзэл сурталын шахалтанд өртөх, мөнгө угаах, авлига, хээл хахууль зэрэг хууль бус үйл ажиллагааг дэмжих, санхүүжүүлэхэд оролцох зэрэг сөрөг нөлөө үзүүлэх өндөр эрсдэлтэй байна.

Түүнчлэн ашгийн бус байгууллага, тэр дундаа ТББ-уудыг дэмжих, хамтран ажиллах төрийн дэмжлэг муу, татвар, санхүүжилтын орчин сул байгаагаас ТББ-уудын үйл ажиллагаа хязгаарлагдмал, гадны санхүүжилт, дэмжлэгээс хараат байдлаар оршин байна.

Иймд ашгийн бус байгууллага тэр дундаа ТББ-уудын ажиллах эрх зүйн орчинг нийгмийн харилцааны өөрчлөлт, эрх зүйн шинэчлэлд нийцүүлэн цогцоор нь шинэчлэх шаардлагатай бөгөөд дараахь асуудлыг хамруулах нь зүйтэй байна:

- Иргэний хуульд ашгийн бус хуулийн этгээдийн төрлийг холбоо, сан, хоршоо хэмээн хязгаарлан зохицуулсныг өөрчлөн, шашны болон нийтийн эрх зүйн хуулийн этгээд зэрэг онцлог хэлбэрийг нэмж хуульчлах;
- Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд ашгийн бус хуулийн этгээдэд хамаарах нийтлэг шаардлагыг нэгдсэн байдлаар хуульчлах, мөн ашгийн бус байгууллагын улсын бүртгэлийн төрлийг шинэчлэн хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэлд холбоо, сан, шашны байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэсэн ангиллаар бүртгэх, үйл ажиллагаанд тавих салбарын хяналтыг тус тусын хуулийн хүрээнд хамруулан зохицуулах. Үүний тулд салбарын хуулиудад тухайн чиглэлийн ашгийн бус байгууллагуудад тавих шаардлага, үйл ажиллагааны болон санхүүгийн хяналтыг нарийвчлан зохицуулах. Ялангуяа ашгийн бус байгууллагын онцлог төрөл болох соёл, боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, шашны байгууллагад тавигдах онцлог шалгуур, хяналттай холбоотой салбар хуулиудын зохицуулалтыг сайжруулах;
- Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг Мэргэжлийн холбоод болон бусад ТББ-аас ялган тодорхойлж, тусгайлан бүртгэх зохицуулалтыг хуульчлах. Түүнчлэн нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хэм хэмжээ тогоосон шийдвэрийг Захиргааны ерөнхий хуулийн хяналтанд бүрэн хамруулах чиглэлд анхаарах;

- Зөвхөн гишүүддээ үйлчлэх зорилгоор ашгийн бус үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн нэгдэл нь заавал хуулийн этгээдээр бүртгүүлэхгүйгээр Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээ болон бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөлийн хэлбэрээр ажиллаж болохыг тодорхой заах, мөн энэ нөхцөлд зөвхөн үндсэн зорилгоо хэрэгжүүлэх хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа явуулахаар хязгаарлах зэргээр ашгийн төлөөх байгууллагаас ялгаатай зохицуулах, түүнчлэн Мэргэжлийн холбоодыг өөрөө зохицуулах байгууллагын хэлбэрээр хөгжүүлэх;
- Гадаадын төрийн бус байгууллагын салбарт зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох эрхийг Гадаадын иргэн, харьяатын газарт олгосон боловч тус зөвшөөрлийг олгох болон олгохоос татгалзах, олгосон зөвшөөрлөө хүчингүй болгох үндэслэл, журам тодорхойгүй, энэ талаарх тусгай журам баталж мөрдүүлэх талаар эрх шилжүүлсэн зохицуулалт байхгүй байна. Иймд холбогдох зохицуулалтыг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлтээр тусгах;
- Хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд хуулийн этгээд болохоос гадна зарим нэг шалгуур, хяналтын тусгай зохицуулалт шаардлагатай боловч редакцийн хараат бус байдлыг хянах, эзэмшлийн хувь хэмжээг хязгаарлах, төвлөрлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт байхгүй байх тул Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн төслийг санаачлах;
- Улс төрийн намыг дэмжигч байгууллага болон шашны олон нийтийн байгууллага зэрэг байгууллагыг ТББ-аар бүртгэн, үйл ажиллагаа явуулах боломжийг нээж байгааг өөрчлөн Улс төрийн намын тухай болон Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн зохицуулалтанд хамруулах;
- Төрийн бус байгууллагын тухай хуулиар ТББ-ын орлогоос ногдол ашиг хуваарилах, иргэн, ААН, байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөх, УИХ, Ерөнхийлөгчийн болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчдэд эд хөрөнгө, хандив өгөхийг хориглосон нийтлэг зохицуулалтыг өргөжүүлэх, улмаар тухайн байгууллагын чиг үүрэг, онцлогоос хамаарч хандив, санхүүжилт авах хүрээ болон үүсгэн байгуулагчдад тавих хязгаарлалтыг салбарын хуулиудад тусгайлан хуульчлах;
- Ашгийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас тавих хяналт сул төдийгүй салбарын хяналт шалгалт нь зөвхөн тусгай зөвшөөрөлтэй хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээгээр, санхүүгийн хяналт нь зөвхөн татвараа үнэн зөв тодорхойлж, бүрэн төлж барагдуулж буй эсэхээр хязгаарлагдаж байгааг өөрчлөх шаардлагатай байна. Иймд үйл ажиллагааны хяналтыг бүртгэлийн байгууллага бус салбарын болон тухайн чиглэлийн ТББ-

уудын холбоо, нэгдэл хариуцуулах, санхүүгийн хяналтын хүрээг өргөжүүлж, санхүүжилтийн эх үүсвэр, түүний хууль ёсны эсэх болон зарцуулалт нь хуульд заасан зохих журмын дагуу байгаа эсэхийг давхар багтаан хуульчлах;

- Эрүүгийн хуулиар террори үйлдэх, террори үйлдэхэд бэлтгэх гэмт хэрэг үйлдснээс бусад тохиолдолд хуулийн этгээдэд татан буулгах албадлагын арга хэмжээ оногдуулах боломжгүй байна. Иймд эдгээрээс гадна нийгэмд илүү сөрөг үр дагавар бүхий гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдийг татан буулгах хариуцлага оногдуулах, мөн зөрчил үйлдсэн хуулийн этгээдэд эрх хасахаас гадна татан буулгах хариуцлага хүлээлгэх шаардлагатайг харгалзан Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт ,өөрчлөлт оруулах;
- 1991 он Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийг тухай хуулийг Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль болон энэ хүрээнд хийгдэх эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан бүхэлд нь шинэчлэн найруулах;
- Төрөөс ашгийн бус хуулийн этгээдийг дэмжих, хамтран ажиллах хэлбэрийг тодорхой хуульчилж, түүнчлэн нийгэмд тустай үйл ажиллагааг татвар, хураамжийн бодлогоор дамжуулан дэмжих, хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Ашгийн бус байгууллагын чиглэлээр хийгдсэн судалгаа, эрх зүйн үнэлгээний дүгнэлтийг харгалзан хууль хоорондын давхардал хийдлийг арилгах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг цогцоор нь шийдвэрлэх;
- Гадаадын иргэн харьяатын газрын олон улсын болон гадаадын хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн сан болон ОӨУБЕГ-ын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн сан хооронд мэдээлэл солилцох, хамтран хяналт хэрэгжүүлэх зохицуулалтыг хуульчлах, холбогдох журмыг баталж мөрдүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Төрийн бус байгууллагын тухай хууль;
3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль;
4. Иргэний хууль;
5. Боловсролын тухай хууль;
6. Соёлын тухай хууль;
7. Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль;
8. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
9. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль;
10. Зөрчлийн тухай хууль;
11. Эрүүгийн хууль;
12. Бусад холбогдох хууль, журмууд.

Ном, судалгаа, шинжилгээний бүтээл

1. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан/Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчлэл/ХЗДХЯ, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоо II” төсөл. 2017 он;
2. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалт(Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа-ХЗДХЯ-2016 он.);
3. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ. (ХЗДХЯ-2017 он.);
4. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн бус байгууллагад төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлэх, 2013 он.;
5. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн бус байгууллагын тухай хуулийн төсөлтэй холбоотой судалгаа, 2011 он.;
6. ОӨУБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон мэдээлэл. 2018 оны 1 дүгээр сар.;
7. Гадаадын иргэн, харьяатын газрын мэдээлэл. 2018 оны 1 дүгээр сар. ;
8. Үндэсний статистикийн хорооны мэдээлэл.2018 оны 2 дугаар сар.;